

**ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ОНОГДУУЛСАН
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Судалгааны захиалагч: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Судалгааны багийн гишүүд:

Б.Алтангэрэл Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

М.Хүрэлбат Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч

Агуулга

Өмнөх үг	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Зураг, хүснэгтийн жагсаалт	5-6
Удиртгал	7-8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ	
1.1. Зорчих эрхийг хязгаарлах ялын ойлголт, онцлог	9-17
1.2. Зорчих эрхийг хязгаарлах ялын түүхчилсэн судалгаа	18-24
1.3. Зорчих эрхийг хязгаарлах ялын эрх зүйн зохицуулалт	25-38
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ	
2.1. Зорчих эрхийг хязгаарлах ялтай холбогдох олон улсын хэм хэмжээ	39-40
2.2. Пост социалист орнуудын зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог	41-50
2.3. АНУ болон Европын зарим орнуудын зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог	51-56
2.4. БНСУ-ын зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог	57-65
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	
3.1. Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулж буй байдал	66-72
3.2. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд хийсэн шинжилгээ	73-78
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	
4.1. Дүгнэлт	79
4.2. Зөвлөмж	80
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	81-84
ХАВСРАЛТ	85-87

Өмнөх үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаачид, практик алба хаагчидтай хамтран “Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ” судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Дэлхий дахины эрүүгийн эрх зүйн бодлого цаг үеийн онцлогоос хамаарч хувьсан өөрчлөгдөж, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэж байна.

Манай улсын хувьд ч мөн адил хорих ялаас татгалзах, ялтны үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний зан байдалд тохирсон ялыг оновчтойгоор хэрэглэх замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан “Эрүүгийн хууль”-д шинэ төрлийн болох “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг нэмж, хэрэгжилтийг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн

“Зорчих эрхийг хязгаарлах ял”-ын түүхэн уламжлал, онолын урсгал, тус албаны чиг үүрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр ял шийтгэл эдлүүлэх гүйцэтгэх үүргийн талаар энэхүү судалгааны ажилд оруулахыг зорьсон ба гадаад хэлнээс орчуулж хийгдсэн болно.

Монгол Улс “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг хэрэгжүүлж эхлээд 1 жил болоогүй хэдий ч энэ удаагийн судалгааны тайлан нь цаашид судлаачдын хувьд онолын чухал материал болохоос гадна практик алба хаагчдын ширээний ном болно хэмээн итгэж судалгааны ажилд үнэтэй санал, зөвлөмжөө өгнө гэдэгт судалгааны багийн гишүүдийн өмнөөс найдаж байна.

Хүндэтгэсэн,
ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР (Ph.D),
ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА

Б.АЛТАНГЭРЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба
ХЯЭА	Хорих ял эдлүүлэх алба
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Зураг, хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Эрүүгийн хууль дахь ялын харьцуулалт (2002/2015)
Зураг 1.	Браслет электронный- Электрон бугуйвч
Зураг 2.	стационарное контрольное устройство- байнгын хяналтын төхөөрөмж
Зураг 3.	мобильное контрольное устройство- хөдөлгөөнт хяналтын төхөөрөмж
Зураг 4.	ретранслятор- дахин дамжуулагч: суурин болон хөдөлгөөнт хяналтын төхөөрөмжийн хүлээн авах хүчин чадлын хүрээг нэмэгдүүлэгч.
Зураг 5.	персональный трекер - алба хаагчийн трекер: Хиймэл дагуулын ГЛОНАСС/GPS системийн тусламжтай байршил тогтоох алсын зайн дохиолол өгөх электрон гавны нэг төрөл.
Зураг 6.	Сервер мониторинга - Мониторинг сервер: бүх мэдээллийг тусгай программ, дэлгэцээр хянах цогц аппарат
Зураг 7.	Сервер аудиовизуального контроля - аудио хяналтын сервер: дуу хоолойн мэдээлэл дамжуулах, хадгалах, хүлээн авах хянах цогц аппарат.
Зураг 8.	Стационарный пульт мониторинга - байнгын удирдах мониторинг.
Зураг 9.	Мобильный пульт мониторинга - Зөөврийн удирдах мониторинг.
Зураг 10.	Олон улсын жишиг
Зураг 11.	Цахим хяналтын системийн нэвтрүүлэх явц
Зураг 12.	Гэмт хэргийг үйлдсэн этгээдийн зорчих хэсгийг хязгаарлана
Зураг 13.	Цахим гавыг хэрэглэж эхлэх
Зураг 14.	Цахим хяналтыг хэрэгжүүлэх дараалал
Зураг 15.	Ял эдлэх субъектийн үүрэг
Зураг 16.	Үүрэг (Тусгай)
Зураг 17.	Цахим гавын хөгжил
Зураг 18.	GPS Байршил тогтоох систем
Зураг 19.	Төхөөрөмжийн танилцуулга
Зураг 20.	Системийн холбоос
Зураг 21.	Байршил тогтоох чанарыг нэмэгдүүлэх /байрлалын цэгийг илүү нарийвчлалтай болгох
Зураг 22.	Улсын хэмжээнд төхөөрөмжийг зүүсэн этгээдийн тоо
Зураг 23.	Хүчингийн гэмт хэрэг гаралтын хувь
Зураг 24.	Хянан харгалзагч болон цагдаагийн байгууллага хоорондын эрх зүйн туслалцаа үзүүлэх хамтын ажиллагаа

Зураг 25.	Шинэчлэн батлагдсан "Эрүүгийн хууль"-д тусгасан ялын төрлүүдийн тус бүрийн эзлэх хувь
Зураг 26.	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа
Зураг 27.	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Нийслэлийн хэмжээнд/
Зураг 28.	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Орон нутгийн хэмжээнд/
Зураг 29.	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Насны ангиллаар/
Зураг 30.	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Хүйсийн байдлаар/
Зураг 31.	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Ял эдлэх хугацаа/
Зураг 32.	2021- 2025 он хүртэл ял эдэлж хугацаа дуусах ялтны судалгаа
Зураг 33.	Давтан гэмт хэрэг үйлдсэн байдлаар
Зураг 34.	Гэмт хэргийн өнгө
Зураг 35.	Зөрчлийн төрөл
Зураг 36.	Хяналтаас гарсан ялтны мэдээлэл
Зураг 37.	"Цахим хяналтын систем"-д ирсэн "анхааруулга" дохионы төрөл, эзлэх хувь
Зураг 38.	Үүрэн холбооны технологийн хөгжлийн зураг.
Зураг 39.	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 34 шийдвэр гүйцэтгэгчээс "Үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал"-ын талаар авсан судалгааны дүн

УДИРТГАЛ

Дэлхийн зарим улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тооны тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл, зарчим давамгайлж байна.

Ял эдлүүлэх ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь өндөр хэмжээний зардлыг үүсгэж байгаагийн зэрэгцээ хорих ял эдлээд суллагдсан хүмүүс нийгмийн орчинд буцаж очих, дахин гэмт хэрэг үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ял хамгийн үр дүн багатай ялын төрөл хэмээн тооцогдож байна.

Хорихоос өөр төрлийн буюу олон улсын эрх зүйд алтернатив ял хэмээн нэрлэгддэг /alternative penalty/ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тусгаарласан байранд тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг¹.

Дэлхийн олон улс, үндэстэн эрүүгийн эрх зүйн ялын бодлого, түүнийг даган гарах хууль эрх зүйдээ хүний эрхийг хангаж, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзаж, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох, хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна².

Манай улсын хувьд мөн ижил хорих ялаас татгалзах, ялтны үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний зан байдалд тохирсон ялыг оновчтойгоор хэрэглэх замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас баталсан “Эрүүгийн хууль”-д шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ялыг нэмж, хэрэгжилтийг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Түүнчлэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ” гэх зорилтын хүрээнд “Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-ийг хөгжүүлэн ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.

¹ Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа: Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2017. 411 дэх тал

² Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018. 29 дэх тал

Зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог, эрх зүйн зохицуулалт Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжсэнээр Үндсэн хуулиар тунхагласан ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрхийг дээдлэх тулгуур зарчимд нийцэх, гэмт этгээд нь нийгэмд ажиллаж хөдөлмөрлөх, гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хороо арилгах боломжоор хангагдахаас гадна уг төрлийн ялаар гэмт этгээдийг шийтгэсэнээр хорих ангид ял эдэлж буй хоригдлын тоо, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг бууруулсаны дүнд төсөвт хэмнэлт хийх зэрэг нийгэм, эдийн засагт олон давуу тал, эерэг ололт бий болгох боломжтой.

Өнөөдрийн байдлаар хоригдолд ногдох нэг өдрийн дундаж зардал 7231 буюу жилд 2.639.619 төгрөг. Харин зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд ногдох нэг өдрийн дундаж зардал 3313 буюу жилд 1.209.173 төгрөг гэх тооцоо, судалгаа гарсан нь хорих ял эдлэгсдийн зардлаас даруй 54.1 хувиар бага байна³.

Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ял нь бусад төрлийн ялаас нийгэмд үр өгөөж өгөхүйц, хууль тогтоомжид заасан эрүүгийн хариуцлага, ялын зорилго бүрэн хангагдах боломжтой, гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэйг төрөхөөс өмнө гурван сар, төрснөөс хойш хоёр жил хүртэл, мөн ганц бие эцэг, эхийг хүүхэд нь хоёр нас хүртэл хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар сольж эдлүүлэх боломж бүрдүүлсэн, гэмт этгээдийг нийгэмшүүлэх өндөр үр нөлөө бүхий ялын төрөл гэдэгтэй судлаачдын хувьд санал нэгддэг.

³ Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд шаардагдах зардлын тооцоо. Хууль зүй, дотоод хэргийн яам. УБ., 2020. 17 дахь тал.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

1.1. Зорчих эрхийг хязгаарлах ялын ойлголт, шинж

Ялын төрлийг хэрэглэх зарчимд туйлын тодорхой санкцийг хуульчлах явдлаас аль болох зайлсхийх, альтернатив нөхцлийг тодорхой боломжит шийдлээр зохицуулж өгөх, жижиг, хүнд биш хэргүүдийн хувьд хянан харгалзах, торгууль, нөхөн төлбөрийн ялыг өргөн хэрэглэх ба баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох (5 хоногоос 3 сар) торгуулийг сүүлийн 6 сар хүртэлх долоо хоног болгон сарын дундаж орлогоор тооцох, мөнгөн дүнгээр илэрхийлэх, тэрчлэн хорихоос өөр төрлийн ялыг өргөжүүлэх, ял солих процедурыг оновчтой хэрэглэх зэрэг практик жишиг гадаадын зарим оронд түгээмэл нэвтэрч хэрэглэгдэж байна.⁴

2002 оны эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын ялын төрөлд / ЭХ-45.2/ ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэж байсан бол 2015 оны шинэчилсэн найруулгаар /ЭХ-5.1.2/ ял ба албадлагын арга хэмжээ гэж өөрчлөн найруулсан байдаг. Ялын төрлийн хувьд 2002 оны эрүүгийн хуулинд торгох, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах гэсэн төрлүүдтэй байсан бол 2015 оны шинэчилсэн найруулгаар торгох, нийтэд тустай ажил хөдөлмөр хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах ялыг нэмэгдэл ялын төрлөөр оногдуулахаар хуульчилсан байна.

Хүснэгт 1. Эрүүгийн хууль дахь ялын харьцуулалт (2002/2015)

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
46 дугаар зүйл. Ялын төрөл 46.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна: 46.1.1.торгох; 46.1.2.тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; 46.1.3.эд хөрөнгө хураах; 46.1.4.албадан ажил хийлгэх; 46.1.5.баривчлах; 46.1.6.хорих; 46.1.7.цаазаар авах.	5.2 дугаар зүйл. Ялын төрөл 1.Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна: 1.1.торгох ял; 1.2.нийтэд тустай ажил хийлгэх ял; 1.3.зорчих эрхийг хязгаарлах ял; 1.4.хорих ял; 1.5.эрх хасах ял. 2.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ. 3.Энэ хуулийн тусгай ангид гэмт хэрэгт оногдуулах үндсэн ялын төрөл, хэмжээг заана.

⁴ Б.Алтангэрэл. "Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ" судалгааны ажлын тайлан.УБ., 2018 он

Уламжлалт ялын төрлүүд болох цаазаар авах, хорих, торгох, нийтэд тустай ажил /албадан ажил/ хийлгэх, албан тушаал эрхлэх болон тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах зэрэг ялаас зорчих эрхийг хязгаарлах ял нь нэлээдгүй онцлог ялгаатай юм. Учир нь энэхүү ялыг хэрэгжүүлэх хамгийн чухал зүйл болох ялтны хөдөлгөөнд цаг алдалгүй хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэгч нь RT болон GPS байршил тодорхойлогч төхөөрөмжүүд болон согтуурал, мансуурал хэмжих багаж зэрэг байдаг. Тиймээс энэ ялын хэрэглээнд дээрх төхөөрөмжийг хэрхэн зөв сонгож хэрэглэх, төхөөрөмжийн өөрийн болоод ашиглалтын өртөг зардал, төхөөрөмжийг ашиглах, нэгдсэн хяналт тавих мэргэжлийн баг, мэргэжилтнүүд байхыг зайлшгүй шаарддаг. Иймээс цаг үедээ нийцсэн технологийн хөгжил, улс орныг бүхэлд нь эсхүл тодорхой бүс нутгийг бүрэн хамарсан сүлжээ байх шаардлага ч урган гарч байна.

Энэхүү ялыг хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг судлах нь зөвхөн хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун бус нөгөө талаасаа мөн техникийн боломж нөхцөлийг судлах шаардлагыг нөхцөлдүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл техник технологийн дэвшилтэд боломжууд нь энэхүү ялыг илүү үр дүнтэй хэрэглэх шинэ шинэ нөхцөл, боломжуудыг бий болгож байгаа юм.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэглээ өнөөдөр зөвхөн АНУ-аар хязгаарлагдахгүй дэлхийн цөөнгүй оронд хэрэгжиж байна. Европт энэхүү ялыг хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж өөрсдийн хууль эрх зүйн тогтолцоонд нутагшуулах хэтийн төлөв харагдаж байна.⁵ Англи /Уэлс⁶, Швед⁷, Голланд⁸ зэрэг улсуудад ялын үндсэн төрөл, суллагдсан ялтанд хяналт тавих, хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө суллах, ялын сонгох санцрын болон шүүх хуралдаанаас өмнө шүүгдэгчид хяналт тавих байдлаар хэрэглэж эхэлжээ. Португал, Франц, Бельги, Итали, Шотланд зэрэг улсуудад 2000 оны орчим энэхүү ялын талаар танилцуулсан⁹ бол Швейцарт 2007 онд энэхүү ялыг буюу үндэсний электрон хяналтын схемийг шинэ эрүүгийн хуульдаа хуульчлан оруулахыг зөвшөөрсөн байна. Дани улсын хувьд 2005 оны 7 сард энэхүү асуудлыг өөрийн улсын парламентаар хэлэлцүүлсэн бол Испани улс нь бүс нутгийн хэмжээнд туршиж үзсэн байна.¹⁰ ХБНГУ-ын Хессе муж улсад электрон хяналтын төхөөрөмж ашиглан зорчих эрхийг хязгаарлах талаарх эхний төслийг

⁵ Hans-Joerg Albrecht. Electronic Monitoring in Europe. A Summary and Assessment of Recent Developments in the Legal Framework and Implementation of Electronic Monitoring

⁶ Mortimer, E., May, Ch.: Electronic monitoring in practice: the second year of the trials of curfew orders. London: Home Office 1997.

⁷ Bishop, N.: Le controle intensif par surveillance electronique: un substitut suedois a l' emprisonnement. Bulletin d' information penologique 19/20(1995), pp. 8-9.

⁸ Ministry of Justice: Electronic Monitoring. The Hague 1996.

⁹ Haferkamp, R.: Elektronisch überwachter Hausarrest - Europa und die Schweiz. Neue Kriminalpolitik 1999, pp. 4-6; Mayer, M., Haverkamp, R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg 2003.

¹⁰ Ceron I Riera, M.: The Pilot Project on Electronic Monitoring in Catalonia, Spain. In: Mayer, M., Haverkamp, R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg 2003, pp. 149-154.

2000 онд хэрэгжүүлсэн ба одоо энэхүү төсөл нь цааш улам өргөжсөөр байна.¹¹ Харин Австрали улсын хувьд электрон хяналтын төхөөрөмжийг харьцангуй эртнээс хэрэглэж эхэлсэн бөгөөд баруун Австралид 1982 оны Батлан даалтын тухай актад 17 нас хүрсэн хүнд шүүхийн офицерын санал болгосноор электрон хяналтыг шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ байдлаар хэрэглэх боломжийг хуульчилсан байна.¹² Үндсэн ялын төрөл болгон хэрэглэх зохицуулалт нь Австрали улсад 1995 оны Ялын тухай актад хуульчлагджээ.¹³

Зорчих эрхийг хязгаарлах – электрон хяналтыг хэрэгжүүлж буй байдал

Электрон хяналтын төхөөрөмжийн буюу байршил тогтоогч төхөөрөмжийн тусламжтайгаар хяналт тавьж буй орнуудын практикийг судлахад нийтлэг байдлаар шүүхийн болоод ял эдлүүлэх ажиллагааны дараах шатанд хэрэглэж байна. Тухайлбал:

1. Ялын төрөл
2. Таслан сэргийлэх арга хэмжээний төрөл
3. Ял эдлэхээс хугацаанаас өмнө буюу тэнсэгдсэн ялтанд хяналт тавих
4. Хорих ял эдлээд суллагдсан ялтанд хяналт тавих

Дээрх төрлүүд нь өөр өөрийн онцлогтойгоор шүүхийн болон түүний өмнөх, эсхүл ял эдлүүлэх, үндсэн ял аа эдэлж дууссаны дараах шатуудыг хамарч хэрэгжиж байгаа боловч эдгээрийн нийтлэг талыг дараах үндэслэлээр харж байгаа юм. Үүнд:

1. RT болон GPS төхөөрөмжийн тусламжтайгаар хяналтыг хэрэгжүүлдэг.
2. Хяналт нь шүүхийн өмнөх шатны таслан сэргийлэх арга хэмжээ эсхүл зорчих эрхээ хязгаарлуулах ял авсан тодорхой нэг хугацааг хамран хэрэгждэг
3. Хяналтын нэгдсэн нэг систем, сүлжээнээс хянагддаг.
4. Хяналтын төхөөрөмжийн түрээс, ашиглалтын зардал зэргийг хянагдаж байгаа хүн хариуцдаг зэрэг нийтлэг талууд байгаа юм.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж буй хэлбэр:

Цахилгаан хяналтын төхөөрөмж нь гэрийн хорио гэсэн ойлголттой ямагт хамт хэрэглэгддэг бөгөөд насанд хүрээгүй ялтны байршлын талаарх болоод бусад шаардлагатай мэдээллүүдийг илтгэдэг. Уг ялыг хорих ялын сонголтод хэлбэр болгосноор цахилгаан хяналтын төхөөрөмж зүүх, зорчих эрхийг

¹¹ Schädler, W.: The Pilot Project on Electronic Monitoring in Frankfurt, Germany. In: Mayer, M., Haverkamp, R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg 2003, pp. 163-168; Mayer, M.: Modellprojekt Elektronische Fußfessel. Wissenschaftliche Befunde zur Modellphase des hessischen Projekts. Freiburg 2004, p. 17.

¹² Nacro Youth Crime 2002, "Electronic monitoring of children remanded on bail or to local authority accommodation", Youth Crime Briefing, June.

Matt Black and Russell G. Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology. Canberra. 2003. p 3.

¹³ Section 44 (3) (b), *Sentencing Act 1995* (NT).

хязгаарлах ял нь илүү өргөн хүрээг хамардаг болсон бөгөөд GPS, дуу хоолойг таних төхөөрөмж, архи согтууруулах ундааг шалгах төхөөрөмж, талбайн хяналтын төхөөрөмж, гар, хөл, бугуйн цахим гав, гэрийн хяналтын төхөөрөмж гэх мэт олон иж бүрдлээс бүрдэж байна.¹⁴

Ерөнхийдөө зорчих эрхийг нь хязгаарласан хүнд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглахын тулд тухайн ялтан этгээдэд гаднын нөлөөтэйгөөр тайлагдахгүй мөн усны болоод тодорхой хамгаалалт бүхий гар, хөлийн цахим гавыг зүүлгэдэг. Уг цахим гав нь тухайн этгээдийн оршин байгаа газар буюу гэрт нь суурилуулсан хяналтын төхөөрөмжөөр дамжуулж дохиог төв рүү илгээдэг.¹⁵ Гэрийн хяналтын төхөөрөмж нь ялтны гэрийн утасны шугамаар дамжуулан төв компьютер-серверт холбогдсон байдаг ба 24 цагийн турш хяналт тавьж мэдээлэл дамжуулах чадамжтай байдаг.

Идэвхгүй хэлбэрийн хяналт гэдэг нь тухайн ялтанд буюу зорчих эрхээ хязгаарлуулсан хүнд цахим гав хэрэглэхгүйгээр утсаар холбогдож, өөрийн байдлыг тайлагнах, байгаа газар болгоноо илтгэж байхыг шаарддаг. Үүний нөгөө талд идэвхтэй радио долгионы хяналтын асуудал яригддаг. Энэ нь ялтны хөдөлгөөн болоод шилжилт хөдөлгөөн бүрийг цаг тухай бүрд нь дамжуулж үргэлжилсэн мэдээллийг ирүүлж байдаг. Хэрэв тухайн зорчих эрхээ хязгаарлуулсан хүнд зүүсэн гар, хөлийн цахим гаваас ирж буй дохио нь өмнө баталсан зорчих хөтөлбөрөөс гажсан буюу зөвшөөрөгдсөн бүсээс гарсан эсхүл хориглосон газруудад зорчсон, очсон байвал төв хяналтын системд аюулын дохиог өгдөг. Ингэснээр зохих эрх бүхий байгууллагад нэн даруй зөрчлийн талаар мэдэгдэж, зохих хариу арга хэмжээг авдаг. Зорчих эрхийн хязгаарлалт, цахим хяналтын нөхцөлийг зөрчсөн, хяналтын бүсээс гарсан, хориглосон газруудад зорсон болоод төхөөрөмжийн ашиглалтад санаатайгаар саад хийсэн, салгахаар болоод эвдлэхээр оролдсон зэрэг хориотой үйлдэл хийсэн ялтнуудыг шинэ зөрчил гаргалаа гэж үзэн ял шийтгэл оногдуулдаг¹⁶. Уг системүүдийг насанд хүрээгүй ялтны сургууль болон хүлээн зөвшөөрөгдөж, урьдчилан төлөвлөсөн ажлын болон бусад газруудад мөн байрлуулдаг байна.¹⁷

Байрлал тогтоох хяналтын төхөөрөмж буюу GPS төхөөрөмж нь ялтны байрлаж байгаа газрыг харуулсан гурван хэмжээс бүхий дүрс ялгаруулах

¹⁴ Gable, Ralph K., and Robert S. Gable. 2005. "Electronic Monitoring: Positive Intervention Strategies." *Federal Probation* 69(1). Kansas Department of Corrections. 2014. *House Arrest—Juvenile Corrections*. Olathe, Kan.: Johnson County Department of Corrections.

¹⁵ National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. *Keeping Track of Electronic Monitoring*. Washington D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.

¹⁶ National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. *Keeping Track of Electronic Monitoring*. Washington D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.

¹⁷ William D., Karen Mann, Thomas G. Blomberg, Gerald G. Gaes, Kelle Barrick, Karla Dhungana, and Brian McManus. 2010. "A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring." Tallahassee, Fla.: Florida State University, College of Criminology and Criminal Justice, Center for Criminology and Public Policy Research

замаар сансрын хиймэл дагуулын тусламжтай байршил тодорхойлдог билээ. Харин идэвхгүй хэлбэрийн GPS төхөөрөмж нь хяналтын төвөөс баталсан мэдээллийг хадгалж, түүнийг шилжүүлж байдаг. Үүний эсрэгээрээ идэвхтэй байрлал тогтоох систем нь яг тухайн цаг мөчид ялтан хаана байгаа талаарх байрлалыг шууд хяналтын төв лүү шилжүүлдэг. Тухайн цаг үеийн байршлын мэдээлэл нь зөрчил гарсан тохиолдолд нэн даруй арга хэмжээ авхуулахаар холбогдох офицер руу нь мэдээлэл өгөх боломжийг олгодог. Мөн уг төхөөрөмж нь ялтан хаана? юу? хийсэн. Урьдчилан батлаагүй байрлалд байсан эсэх талаарх мэдээллээр хангадаг. Энэхүү байрлал тогтоох төхөөрөмжийг ашигласнаар ялтнуудын гэмт хэрэг үйлдэх сэдэл, зан үйл багасаж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах замаар ялтны эрх чөлөөг /зорчих эрх/ хязгаарладаг.¹⁸

Мөн судалгаагаар уламжлалт гэрийн хорионд байх болон цахилгаан хяналтын төхөөрөмж, цахим гавын хяналтад байх хоёрын үр дүн нь адилхан гарсан байна.¹⁹ 300 гаруй насанд хүрээгүй хүмүүсийн дунд явуулсан судалгаагаар уламжлалт гэрийн хорионд байгаа болон цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад байгаа хүмүүсийн дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл, тоо хэмжээ нь адилхан байсан²⁰ гэсэн судалгааны үр дүн байна. 288 насанд хүрээгүй хоригдлуудаас судалгаа авахад тэдгээрийн тал хувь нь байнгын хяналтад, үлдсэн тал хувь нь хагас хяналтад байдаг ба хяналтын чанга, сулаасаа болон тогтмол, түр зуурын байгаагийн хооронд төдийлөн ялгаа гараагүй ажээ.²¹

Флорида мужийн Цахилгаан хяналтын төхөөрөмжийн тогтолцооны талаар судалгаа гаргасан ба Флорида мужийн Засан сайжруулах газар нь 1987 оноос эхлэн уг төхөөрөмжийг ашиглаж ирсэн байна. Тэдний гаргасан судалгаанд бусад нийгэмшүүлэн засан сайжруулах хөтөлбөрүүдээс илүүтэйгээр цахилгааны хяналтын төхөөрөмж нь 31 хувиар эрсдэлийг бууруулсан гэсэн дүн гарчээ. GPS төхөөрөмж нь радио долгионы /RT/ төхөөрөмжөөс илүүтэйгээр үр ашигтай бөгөөд шууд үр дүнг илтгэж, хяналт алдах эрсдэлийг 6 хувиар бууруулсан байна. Цахилгаан хяналтын төхөөрөмж нь биеэ үнэлэх, өмчийн

¹⁸ Stephen V., Randy Gainey, Marcia I. Cohen, Eoin Healy, Martha Yeide, Alan Bekelman, Amanda Bobnis. 2013. Monitoring High-Risk Gang Offenders with GPS Technology: An Evaluation of the California Supervision Program Final Report. Bethesda, MD: Development Services Group.

¹⁹ Bonta, James, Suzanne Wallace-Capretta, and Jennifer Rooney. 2000. "Can Electronic Monitoring Make a Difference? An Evaluation of Three Canadian Programs." *Crime and Delinquency* 46(1):1-75.

²⁰ Wiebush, Richard G. 1993. "Juvenile Intensive Supervision: The Impact on Felony Offenders Diverted from Institutional Placement." *Crime and Delinquency* 39(1):68-89.

²¹ Development Services Group, Inc. 2014. "Home Confinement and Electronic Monitoring." Literature Review. Washington, DC.: Office of Juvenile Justice and Delinquency Prevention.

http://www.ojjdp.gov/mpg/litreviews/Home_Confinement_EM.pdf

эсрэг, архи согтууруулах удаа хэрэглэсэн гэх мэт хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хэрэглэхэд илүү нөлөө үзүүлдэг байна.²²

Цахилгаан хяналтын төхөөрөмжийг гэмт этгээдийн эрх чөлөөг хязгаарлах үндсэн ялын төрлөөр ашиглаж болно. Жишээлбэл, ялтанг ял эдлэх хугацаанд нь гэрийн хорионд ялыг эдлүүлэхдээ цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигладаг. Шүүх хуралдаанаас өмнөх үе шатны цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэх хэрэглээтэй уг үе шатыг харьцуулахад энэ тохиолдолд шүүхээс тухайн этгээдийг гэм бурууг тогтоож ял байдлаар оногдуулдаг. Иймд цахилгаан хяналтын төхөөрөмж нь хянахаас илүүгээр хорих шинжтэй байдаг. Цахилгаан хяналтын төхөөрөмж нь ялтанг хохирогчийн эсрэг болон дахин гэмт үйлдэл хийхээс урьдчилан хянаж, эрх чөлөөнд нь хязгаарлалт тавьж байдаг.

Цахилгаан хяналтын төхөөрөмжийн өөр нэгэн ашиг тус нь байрлал тогтоох төхөөрөмж буюу гар, хөлийн цахим гавыг ашигласнаар гэмт этгээдийн тухайн мөчлөгт хаана байгаа бодит байрлалыг шууд тогтоох боломжийг олгодог. Ингэж байрлал тогтоосноор насанд хүрээгүй хүмүүсийг урьдчилан төлөвлөж зөвшөөрсөн буюу хөтөлбөрийн дагуух байрлалаар явж байна уу, үгүй юу гэдгийг хянах боломжтой. Мөн тухайн этгээдүүд нь өөрсдийн хийгээгүй гэмт хэргийн төлөө буруутгагдах эрсдэлийг бууруулахаас гадна хохирогч руу халдах, дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрдсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авах боломжийг бүрдүүлдэг.²³ Мөн үүнээс гадна зорчих эрхийг хязгаарлах ялын ашигтай чанарын талаар дурдахгүй байж болохгүй нэг нөхцөл байдал нь ялтныг гэр бүлтэйгээ дахин нэгдэх, нийгэмдээ хөл тавьж нийгэмших, нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжих, засрал төлөвшлийг олох боломжийг бий болгодогт оршино.

Цахим хяналтын төхөөрөмж, цахим гавтай байх нь физиологи, сэтгэл санааны сөрөг нөлөөллийг алга болгох, багасгах ашиг тустай хэдий ч цахим хяналтын төхөөрөмжийг өөртөө зүүж авч явах нь сэтгэл зүйн дарамтад оруулах, үе тэнгийнхэн болон бусад хүмүүсээс ичих, санаа зовних явдлыг бий болгодог гэж үздэг судлаачид ч байна.

Цахим хяналтын төхөөрөмж буюу нэн ялангуяа 24/7 хяналт тавих боломжтой GPS төхөөрөмжүүд нь байршлаа мэдээлэх, дохио дамжуулах чадвар, чадамж хязгаарлагдах тохиолдлууд байдаг. Цаг уурын нөхцөл байдал болоод орчны нөхцөл байдал, газар зүйн байршил зэргээс болж дохио сарних,

²² Bales, William D., Karen Mann, Thomas G. Blomberg, Gerald G. Gaes, Kelle Barrick, Karla Dhungana, and Brian McManus. 2010. "A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring." Tallahassee, Fla.: Florida State University, College of Criminology and Criminal Justice, Center for Criminology and Public Policy Research.

<http://www.criminologycenter.fsu.edu/p/pdf/EM%20Evaluation%20Final%20Report%20for%20NIJ.pdf>

²³ Sklaver, Stacey L. 2010. "The Pros and Cons of Using Electronic Monitoring Programs in Juvenile Cases." Juvenile Justice Committee Newsletter, No.5. Washington, D.C.: American Bar Association.

тасалдах, алга болох үзэгдэл өнөөдрийн технологийн үсрэнгүй хөгжилтэй дэлхий дахинд ч даван туулж чадаагүй техникийн шинжтэй асуудал хэвээр байгаа юм. Тиймээс цахилгаан хяналтын төхөөрөмж, цахим гав хэрэглэн хяналт тавих, ял шийтгүүлсэн эсхүл цахим хяналтын төхөөрөмжийн хүрээнд батлан даалтад байгаа, ял тэнсэгдсэн ялтнуудын хөдөлгөөнд тогтмол хяналт тавих боломж нь тодорхой хязгаартай гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Мөн ялтнууд нь гэрч, хохирогч эсхүл өмнө яллах ажиллагаанд оролцож байсан хүмүүс рүү халдлага хийхэд биет хамгаалалтыг хийх, хязгаарлах нөхцөл байдал нь сул байдаг. Зарим судлаачид тохиолдолд цахим хяналтын төхөөрөмжийг ашигласан нь гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэлийг бий болгож байна гэж үздэг судлаачид байгаа юм. Цахим хяналтын төхөөрөмжийн үр нөлөөг сайжруулахын тулд тухайн улсын бүх газрыг хяналтын төхөөрөмж холбогдон ажиллах боломжтой сүлжээтэй /интернэтийн утасгүй сүлжээ болон бусад/ болгох, нийгмийн хяналтын сүлжээг сайжруулах хэрэг гардаг.

Эрүүгийн эрх зүйд, тэр дундаа ял эдлүүлэх эрх зүйн хүрээнд цахилгаан хяналтын төхөөрөмж, цахим гавыг ашиглах нь ёс зүй, хууль эрх зүй болон практикт тулгамдсан олон асуудлуудыг бий болгож байна. Цахилгаан хяналтын төхөөрөмжийн гол ач тус нь тухайн гэмт хэрэг үйлдэн ял шийтгүүлсэн хүнийг засан сайжруулах, засрал хүмүүжлийг олоход нь туслах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг хэдий ч төхөөрөмж, техник технологиор дамжуулан хязгаарлалт, хараа хяналт тогтоох нь ял шийтгэлтэй адил нөхцөл байдлуудыг үүсгэдэг хэмээн үздэг судлаачид байна. Ял шийтгэлээс өөр үр нөлөөтэй байсан ч цахилгаан хяналтын төхөөрөмж нь хувь хүний эрх чөлөөнд хязгаарлалтуудыг тавьдаг.

Зорчих эрхийн хязгаарлалтад буюу цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад ял эдлээгүй үлдсэн хугацаанд байлгах нь байнгын хяналт, хязгаарлалт багатай орчинд ял эдлүүлж цаашдаа гэр бүл, хамт олны дунд нийгэмдээ дасан зохицох, гэмт хэрэг дахин үйлдэхгүй байх боломжийг нөхцөлдүүлдэг. Жишээлбэл, Шинэ Зеландад явуулсан цахилгаан хяналтын төхөөрөмжийн үнэлгээний талаарх судалгаанд гэрийн хорионд гарсан ялтнууд нь уг төхөөрөмжид сэтгэл ханамж сайн байгаа бөгөөд шоронд байх үеийн дарамт, шахалт, сүрдүүлгээс хол байх, зайлсхийх боломжийг олгож байна гэжээ.

Цахилгаан хяналтын төхөөрөмж нь хүний бие, физиологитой үргэлж хамт байх шаардлагатай байдаг түрэмгий технологи юм. Өөрөөр хэлбэл уг төхөөрөмж нь хүний хийж байгаа бүх үйлдлийг илтгэдэг.

Цахилгаан хяналтын төхөөрөмжийн практик хэрэглээ, цар хүрээний талаар хэд хэдэн асуултууд үүсэн гардаг. Тухайлбал төхөөрөмжийг хүний биед суурилуулахдаа хүч хэрэглэхийг зөвшөөрдөг үү? Мэс заслын аргаар цахилгаан

хяналтын төхөөрөмжийг суулгах нь зөв зохистой юу? Хөл хорионы цагийн хугацаанд ялтанг хяналтад байлгасан бол хөл хорионы бус цагаар чөлөөтэй хөдөлгөөн хийх эрхтэй юу? Ялтны хөдөлгөөний талаарх мэдээллийг юунд зориулан хадгалж авдаг вэ?²⁴ гэх мэт.

Аж үйлдвэрлэл, технологийн хөгжил нь цахилгаан хяналтын төхөөрөмжийн хэрэглээний өсөлтөд гол байр суурьтай оролцож байгаа. Зарим эрх зүйн тогтолцоонд ялтанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг суурилуулдаг, түүнийг хянадаг хувийн хэвшлийнхэн бий болсон байна. Уг өсөлттэй холбоотойгоор хувийн хэвшлийнхэнд цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаар сургалт, үйлчилгээний чанар, тооцоо бүртгэл гэх мэт хяналтын менежментийг сайжруулах үүрэг үүсэж байгааг дурдахгүй байж болохгүй.

Мөн уг төхөөрөмжтэй холбоотой санхүүгийн асуудлууд үүсдэг. Цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж байгаа ялтнуудыг төхөөрөмжийн ашиглалтын болоод хяналтын зардлыг төлөхийг шаарддаг. Энэ нь ихэвчлэн ажиллах тохиромжтой газраа олсон хөдөлмөр эрхэлж байгаа ялтнуудтай холбоотойгоор яригдаж байна. Гэсэн хэдий ч нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдаж байгаа бүх ялтнууд нь засан сайжруулахад гарсан зардлыг төлөх нь зүй ёсны юм. Гэхдээ энэ нь бага орлоготой эсхүл гэр бүлийн орлого багатай хүмүүст хүндээр тусч болзошгүй юм.

Өөр нэгэн асуудал байгаа нь цахилгаан хяналтын төхөөрөмж нь үр ашигтай эсэх, шоронд хоригдох хүмүүсийн тоо болон гарах зардлыг бууруулах бодит боломжтой эсэх юм. Цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигласнаар шоронд хорихоос илүү зорчих эрхийг хязгаарлах нөхцөлтэйгөөр нийгэмд гаргах нь ялтнуудыг нийгэмшиж, бүгдийг шинээр сайхнаар эхлэхэд дэмжлэг үзүүлж чадаж байгаа юу гэдэг нь гол асуудал болж байгаа юм. Зарим судлаачид, хуульчид уг төхөөрөмж нь ялтнуудыг нийгэмшүүлж, дахин нийгэмдээ шинээр амьдрах, хөдөлмөр эрхлэхийг дэмжих, өөрийн гэр бүлтэйгээ илүү ойр харилцаатай байх боломж олгож байна. Энэ л боломжууд ялтнуудыг шоронд хорихоос илүүтэйгээр зан авирыг нь өөрчлөхөд илүү дөхөм үзүүлдэг гэсэн байна. Гэсэн хэдий ч үүнд асуудал үүсэж байгаа нь хэрэв гэр бүлийн гишүүдтэй, нийгэмтэйгээ харьцах уг харилцааг хаасан, гэр бүлийн гишүүдтэй уулзах хугацаа тогтоосон бол яах вэ? Дээрх боломжууд гарах уу? гэдэг дээр асуудал байна гэж харж байгаа хуульчид ч байгаа юм. Уг асуудлыг хэрхэн зохицуулж, илүү нийгэмших боломжийг олгох талаар цаашид судалгаа шаардлагатай байна.

²⁴ Жишээлбэл Америкийн Нэгдсэн Улсад хэрэв гэмт этгээд гэмт хэрэг үйлдэх болзошгүй тохиолдолд эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх, гэмт хэргийг баримтжуулах зорилготой байдаг.

Эрх зүйн янз бүрийн тогтолцоонд цахилгаан хяналтын төхөөрөмжийн хэрэгжилт өндөр түвшинд амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал Их Британид 80 хувь, Швед Улсад 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Шинэ Зеландад цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэх гүйцэтгэлийн хувь өндөр байгаа ба мөн дахин гэмт хэрэг үйлдэх хувь буурсан үзүүлэлтүүдтэй байна.

1.2. Зорчих эрхийг хязгаарлах ялын түүхчилсэн судалгаа

Энэхүү ялын анхны үзэл санааг Английн алдарт философич Ж.Бентамыг гаргасан гэж үзэх хүмүүс байдаг. 18-р зууны үед тэрбээр “Паноптикон” /panopticon/ хэмээх хорих байрны загварыг гаргасан байна. Энэхүү байрны онцлог нь байгууламжийн голд цамхагт ганцхан харуул байх ба харуул хаашаа харж байгааг хоригдлууд мэдэх боломжгүй гагцхүү хяналтад байгаа гэсэн сэтгэл зүйд тулгуурлан хорих байрыг зохион байгуулах санааг гаргаж байжээ²⁵.

Зарим судлаачид Ж.Бентамын энэ загвар нь ирээдүйд зорчих эрхийг хязгаарлах ял, электрон хяналтын гавын талаарх үзэл санаа бүрдэх үүсэл болсон гэж үздэг ажээ. Харин бодитоор зорчих эрхийг хязгаарлах ял амьдралд хэрэгжих боломж бүрдэж эхэлсэн үе нь 1960-аад оны үе бөгөөд АНУ-ын Харвардын Их сургуулийн Роберт болон Кирк Габле нар²⁶ цахим хяналтын гавыг цэргийн технологид хэрэглэж байсан радио долгион дамжуулах төхөөрөмжид уялдуулан бүтээсэн боловч шүүхийн практикт үүнээс бүр хожим 1983 онд АНУ-ын Нью-Мексико мужид хэрэглэсэн байдаг. Үүнээс хойш нэг жилийн дотор АНУ-ын Флорида муж улсад энэ ялын хэрэглээний талаар томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Ингээд 80-аад оны сүүл хэсэг гэхэд АНУ-ын олон мужуудад зорчих эрхийн хязгаарлалт, цахим гав, электрон хяналт хэрэглэх ялын олон төрөл янзын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлжээ.²⁷ Үүний дараа Канад, Австрали, Сингапур, Израйл улсууд дээрхээс санаа авч өөр өөрсдийн орны онцлогт тохирсон хөтөлбөрүүдийг боловсруулж эхэлсэн байна.²⁸ Харин Европын улсуудад нэвтрэхэд нэлээд удаашралтай байжээ.

1989 онд Европын улсуудаас анхлан ИБУИНВУ-ын Англид цахим гав, электрон хяналтын хөтөлбөрийг шүүхээс өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээний төрөл хэлбэрээр анхлан хэрэглэж, туршиж эхэлсэн байдаг.²⁹ Ерээд оны эхэн үеэс Нидерланд, Швед улсуудад шоронд хоригдож буй хоригдлуудын тоо илэрхий өсөх болсон ажээ.³⁰ Шоронд хоригдож буй ихэнх хоригдлууд нь хүч хэрэглэсэн гэмт хэрэг, бэлгэсийн эсрэг гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодисын хууль тогтоомж зөрчих зэрэг гэмт хэрэг холбогдсон хоригдлууд эзэлж байсан ба мөн хорих ял эдэлж буй ялтныг хугацаанаас өмнө суллах орчин нөхцөл хязгаарлагдмал байсан байна. Ингээд дээрх хоёр орон эрүүгийн эрх

²⁵Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам /Харьцуулсан судалгаа/ судалгааны тайлан.2016 он

²⁶ Harvard Law Review 1966-67, p. 403-421; Gable (former Ralph Schwitzgebel), Journal of Criminal Justice 1986, p. 168; Schwitzgebel, Law and Computer Technology 1969, p. 9; Schwitzgebel, Lex et Scientia 1968, p. 99.

²⁷ Jolin/Rogers, Journal of Contemporary Criminal Justice 1989, p. 141; Schmidt, Journal of Contemporary Criminal Justice 1989, p. 138.

²⁸ RITA HAVERKAMP. Implementing Electronic Monitoring A comparative, empirical study on attitudes towards the measure in Lower Saxony/Germany and in Sweden. p. 13.

²⁹ G Mair; C Nee. Electronic Monitoring: The Trials and Their Results. 1990. <https://www.ncjrs.gov>

³⁰ Compare the overview of the average prison population of Walmsley 1998.

зүйд тэр дундаа ялын эрх зүйд томоохон өөрчлөлт оруулж ял шийтгэлийн бодлогыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх алхмуудыг хийж эхэлсэн юм. Энэ нөхцөлд цахим гав, электрон хяналтын төхөөрөмж нь хорих ялын хамгийн боломжит сонголтод хэлбэр байж болох талаар үзэл санаа гарч энэхүү ялыг хэрэглэж эхэлсэн байна. Удалгүй энэхүү үзэл санаа нь Баруун Европын бусад улсуудад нэвтэрч эхэлсэн ба тухайлбал Бельги, Герман, Франц, Итали, Португал, Швейцар зэрэг улсын шүүхээс цахим гав, электрон хяналтыг хэрэглэн хяналт тавих ялыг оногдуулах болжээ.

1990-ээд оноос эхлэн дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйд, тодруулбал улс орнуудын ялын бодлогод зорчих эрхийг электрон хяналтын төхөөрөмж, цахим гавын тусламжтайгаар хязгаарлах ял, арга хэмжээний эзлэх байр суурь өсөн нэмэгдэж, томоохон байр суурийг эзлэх болсон байна.³¹

XX зууны 2-р хагас буюу 1960-аад оны үеэс АНУ-ын Харвардын Их сургуулийн нийгмийн сэтгэл зүйн салбарынхан электрон хяналтын төхөөрөмж /цахилгаан гав/ нь Эрүүгийн шүүхийн тогтолцооны чухал хэсэг болох тухай саналыг дэвшүүлж байсан байна. Тухайн үед Харвардын сэтгэл зүйн салбарт Роберт болон Кирк Габле нар алдартай сэтгэл зүйчид болох Скиннер болон Тимоти Лири нарын дор сурлаж байжээ. Тэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өсвөр насны хүүхдүүдийг хөдөлгөөнийг хянах тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр судалгааг явуулж байжээ. Тэдний судалгааны гол зорилго нь дээрх хүмүүсийн байрлал, байршлыг цаг тухайд нь мэдэх боломжийг эрэлхийлж байсан явдал юм. Ингэхдээ хуучны цэргийн төхөөрөмжийг суурь болгон ашиглаж энэхүү төхөөрөмж нь зүүсэн үед өөрийн байршлыг хаанаас ч дамжуулж байлаа.³²

Хэдийгээр зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэх техник, технологийн боломж, үндэс суурь нь 1960-аад оны үед бий болсон боловч уг ялыг шүүхийн практикт хэрэглэх хүртэл дахиад 20 орчим жил болжээ. АНУ-ын Нью-Мексико муж улсын шүүгч Жэк Лов 1983 онд энэхүү ялыг анх удаа хэрэглэн шүүхийн шийдвэр гаргасан юм.³³ Харин 1987 он гэхэд уг ялаар шийтгүүлэгсдийн тоо үндэсний хэмжээнд 826 болсон³⁴ бол 1997 онд 75.000³⁵ 1998 онд энэ тоо ойролцоогоор 95000 болжээ.³⁶

³¹ Haverkamp, in: Neue Kriminalpolitik 1999/4, p. 4.

³² Emma Anderson. The Evolution of Electronic Monitoring Devices. <http://www.npr.org>

³³ James Kilgore. Electronic Monitoring Is Not the Answer Critical reflections on a flawed alternative. Urbana-Champaign Independent Media Center A part of the Media Action Grassroots Network (MAG-Net). 2015. p 8.

³⁴ A. K. Schmidt, "Use of Electronic Monitoring by Criminal Justice Agencies" (Washington, DC: Report for National Criminal Justice Research Service, 1988).

³⁵ Offender electronic technology. Community Corrections Resource [second edition]. Bureau of Justice Assistance U.S. Department of Justice. 2005. P 16.

³⁶ National Law Enforcement and Corrections Technology Center, Online Bulletin, National Institute of Justice (1999),

1990-ээд оны дунд үеэс GPS төхөөрөмжийн тусламжтайгаар ялтан д хяналт тавих боломжтой болсон юм. Энэхүү төхөөрөмжийг хэрэглэх нөхцөл бүрдсэнээр тодорхой бүс нутаг, чиглэлийн хүрээнд хяналт тавих боломжтой болсон гэж үзэж болно.³⁷ Мэргэжилтнүүдийн тооцоолж байгаагаар 2014 оны байдлаар АНУ-д 160.000 төхөөрөмж хэрэглэгдэж байгаагаас төхөөрөмжүүдийн тал хувийг GPS төхөөрөмж эзэлж байгаа бол үлдсэн хувийг RT төхөөрөмж эзэлж байна.³⁸ Судлаачдын тооцоолж буйгаар АНУ-д жил бүр 300.000 орчим хүнд энэхүү ялыг хэрэглэж байна.³⁹ Мөн энэхүү тоон дээр 50.000 орчим согтууруулах ундаа, мансууруулах бодис хэмжигч бас нэмэгдэж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг эхлэн хэрэгжүүлэхэд дээрх технологийг хэрэглэдэг байсан ч хэрэглээ нь өнөөг хүртэл байсаар байгаа юм. АНУ-ын агаарын цэргийн хүчин GPS /general positioning system/ буюу хиймэл дагуулын тусламжтайгаар байршил тогтоох технологийг бүтээсэн нь 1990-ээд оны үеэс эхлэн иргэний хэрэглээнд нэвтэрч эхэлсэн. Үүнтэй зэрэгцэн зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд GPS технологийг хэрэглэж эхэлжээ. Дэлхийн тойрог замд байгаа 24 хиймэл дагуулын тасралтгүй дохио хүлээн авч дамжуулах технологи дээр суурилан ажилладаг GPS технологийн тусламжтайгаар бүтээгдсэн электрон гавын зүүсэн хүнийг зөвхөн гэрт нь байрлуулсан төв дамжуулагчийн радиусаар бус тодорхой замын дагуу бүтэн цагийн хяналт тавих боломж нь ялын хэрэглээг шинэ түвшинд аваачиж байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэнд энэ төрлийн ял нь урд өмнө хуульчлагдан хэрэглэгдэж байгаагүй бөгөөд харин уг нутгаас зайлуулах, цөлөх зэргээр нутаг заах, амьдрах газар заах ялуудыг хэрэглэж байсан шүүхийн практик бий. Энэхүү ялууд нь нэг талаас тухайн этгээдийн зорчин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хөндөж байгаагаараа ижил боловч ялын үндсэн агуулга, зорилгоороо ялгаатай байгаа юм.

Энэхүү ялын нэр томъёоны талаар эрх чөлөө хязгаарлах, зорчих эрхийг хасах, гэрийн хорио зэргээр хэд хэдэн нэршлээр томъёологдож байгаа юм. Тухайлбал Др Д.Баярсайхан өөрийн бүтээлдээ гэрийн нөхцөлд хорих ял нь 1984 оноос хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тухайн этгээдийн амьдарч буй орон байранд нь хатуу хязгаарлалтын дор хорьж цагдах ял юм.⁴⁰ гэж томъёолсон байна.

³⁷ James Kilgore. Electronic Monitoring Is Not the Answer Critical reflections on a flawed alternative. Urbana-Champaign Independent Media Center A part of the Media Action Grassroots Network (MAG-Net). 2015. p 8.

³⁸ Interview with George Drake, President of Correct Tech, LLC, September 3, 2014, and July 30, 2015.

³⁹ This includes immigration detention-related uses, juvenile justice, and domestic violence cases that may not involve a parole/probation component.

⁴⁰ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012. 248-249 дэх тал.

Сэдвийн хүрээнд electronic monitoring (EM) /цахим хяналт/, ankle bracelet /хөлийн гав/ radio frequency /радио долгионы төхөөрөмж/ GPS /газар зүйн байршил тодорхойлогч/ home confinement /гэрийн хорио/ зэрэг олон Англи хэл дээрх нэр томъёонууд өргөн хэрэглэгдэж байгаа юм. Монгол Улсын хувьд 2015 онд батлагдсан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд Зорчих эрхийг хязгаарлах ял гэж томъёолж өгсөн. Үүнээс өмнө боловсруулагдаж байсан Гэмт хэргийн тухай хуульд Гэрийн хорио ял гэсэн нэршлээр тусгагдаж байсан байна.

Нэр томъёоны хувьд шууд авч хэрэглэх нь асуудалтай гэж үзэж байгаа юм. Тухайлбал гэрийн хорио ял гэсэн энэхүү нэршлээр авч хэрэглэх нь асуудалтай байна. Тодруулбал хэдийгээр зөвхөн гэрт нь хорихоос гадна мөн энэхүү ялын ойлголт нь электрон хяналтын төхөөрөмж хэрэглэх болон хэрэглэхгүйгээр тодорхой замаар, тодорхой бүсэд, тодорхой цагийн хуваарьт зорчих байдлаар ял, хариуцлага нь оногддог. Иймээс зөвхөн гэрийн хорионд байгаа хэрэг биш юм. Харин зорчих эрхийг хязгаарлах ял гэсэн нэршил нь нэлээдгүй оновчтой томъёолол болж өгсөн гэж судлаачийн зүгээс үзэж байна. Ялын үндсэн үзэл санаа нь ял шийтгүүлсэн этгээдийг гэрт нь буюу байнга амьдрах газарт нь хөл хорих хэлбэрээр хэрэгжиж байгаа юм. Гэхдээ тухайн ял шийтгүүлсэн ялтан нь цахим гав буюу цахим хяналтын төхөөрөмж бүхий байршлын талаарх мэдээлэл бүхий дохиог дамжуулах гаднын нөлөөлөлд тэсвэртэй зориулалтын бусаар тайлах, суллах боломжгүй гав /төхөөрөмж/-ыг зүүж байх үүргийг хүлээдэг. Ингээд мөн урьдчилан тогтоосон замаар, тогтоосон цагийн хүрээнд ажил, гэр, сургууль руугаа явах боломжийг олгодог.

Манай улсын хувьд уламжлалт ялын төрлүүд болох цаазаар авах, хорих, торгох, нийтэд тустай ажил /албадан ажил/ хийлгэх, албан тушаал эрхлэх болон тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах зэрэг ялаас зорчих эрхийг хязгаарлах ял нь нэлээдгүй онцлог ялгаатай юм. Учир нь энэхүү ялыг хэрэгжүүлэх хамгийн чухал зүйл болох ялтны хөдөлгөөнд цаг алдалгүй хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэгч нь RT болон GPS байршил тодорхойлогч төхөөрөмжүүд болон согтуурал, мансуурал хэмжих багаж зэрэг байдаг. Тиймээс энэ ялын хэрэглээнд дээрх төхөөрөмжийг хэрхэн зөв сонгож хэрэглэх, төхөөрөмжийн өөрийн болоод ашиглалтын өртөг зардал, төхөөрөмжийг ашиглах, нэгдсэн хяналт тавих мэргэжлийн баг, мэргэжилтнүүд байхыг зайлшгүй шаарддаг. Иймээс цаг үедээ нийцсэн технологийн хөгжил, улс орныг бүхэлд нь эсхүл тодорхой бүс нутгийг бүрэн хамарсан сүлжээ байх шаардлага ч урган гарч байна. Тиймээс энэхүү ялыг хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг судлах нь зөвхөн хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун бус нөгөө талаасаа мөн техникийн боломж нөхцөлийг судлах шаардлагыг нөхцөлдүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл техник технологийн дэвшилтэд боломжууд нь энэхүү ялыг илүү үр дүнтэй хэрэглэх шинэ шинэ нөхцөл, боломжуудыг бий болгож байгаа юм.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь манай улсын хууль тогтоомжийн түүхэнд байгаагүй боловч түүнтэй төстэй тухайн иргэний үндсэн эрх болох оршин суух газраа чөлөөтэй сонгох, улс орны нутаг дэвсгэр дээр иргэн хүнийхээ хувьд амьдрах газраа сонгох үндсэн эрхэд хязгаарлалт тогтоож байсан ялын төрлийг судлан авч үзлээ. Ингэхдээ Монгол Улсын хувьд эрүүгийн хууль тогтоомжийн тэр дундаа ялын эдлүүлэх эрх зүй судлалын хүрээнд 1924 оны анхдугаар Үндсэн хууль батлагдаж манай улсад орчин үеийн эрх зүйн тогтолцоо бүрэлдэн бий болох эхлэл тавигдсан мөчөөс хойших цаг хугацааны мөчлөгт судалсан болно. Манай улсад гав гинж зүүлгэн айлаар хэсүүлж хорих, газар нүхэнд хорих, малын нойтон арьс шир, эсгийд ороох гэх мэт эрх чөлөөг хязгаарласан ялын төрлүүдийг хэрэглэж байсан. 1926 онд БНМАУ-ын Шүүх цаазын бичгийг батлан гаргасан бөгөөд уг Шүүх цаазын бичигт Нутаг зайлуулах буюу Нутаг зааж суулгах ялыг хуульчилж өгсөн байна.⁴¹

Нутаг зааж суулгах ял шийтгэгдсэн этгээд уг нутагт очих замаасаа оргох буюу зааж суулгасан нутгаас оргон зайлсхийвэл гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ⁴². Нутаг заах ялын зорилго нь ялтныг гэмт хэрэг дахин үйлдэх орчны нөхцөлөөс тусгаарлаж, тэр этгээдийн нийгмийн эсрэг зан төлөвийн сөрөг нөлөөллөөс бусдыг урьдчилан сэргийлэхэд оршино гэжээ. Нэг ёсны нутаг заагдсан этгээд тогтоосон хугацааны дотор тэрхүү нутгаас гадагш гарч явах эрхгүй гэсэн үг бөгөөд энэ нь ялтны засрал хүмүүжилд эерэг нөлөө үзүүлж чадна гэж үзсэн нөхцөлд уг ялыг оногдуулдаг байжээ. Нутаг заах ялыг нэмэгдэл ял болгон оногдуулсан тохиолдолд үндсэн ялыг эдэлж дууссан дараа эдлүүлдэг бол ялтан засран хүмүүжихэд нийгмээс тусгаарлан хорих ял оногдуулах шаардлагагүй гэж үзвэл үндсэн ялын чанартай хэрэглэдэг.

Нутаг заах ялыг хоёр жилээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар оногдуулдаг байсан бөгөөд гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан этгээд, 8 хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулахыг хориглодог байжээ.

Харин Уг нутгаас зайлуулах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн оршин байгаа тодорхой нутгийн орчин нь түүний цаашид дахин гэмт үйл ажиллагаа үргэлжлүүлэхэд нь нөлөөлөх юм уу эсхүл уг этгээд оршин суудаг нутагтаа байх нь бусад хүмүүсийг гэмт хэргийн замт татан оруулж болох муу нөлөөтэй нөхцөлд үндсэн болон нэмэгдэл ялын аль нэг хэлбэрээр оногдуулна⁴³. Уг нутгаас зайлуулах ял нь ялтныг тодорхой нутагт оршин суух эрхийг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хасдаг учир заасан нутагт эргэж ирэх эрхгүй, харин оршин суух нутгаа сонгож авах эрхтэй байдаг байна. Уг нутгаас

⁴¹ Б.Баярсайхан, С.Жанцан. "Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он)". УБ., 2001. 91 дэх тал

⁴² Б.Содовсүрэн. "БНМАУ-ын Эрүүгийн эрх". УБ., 1969.

⁴³ БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1989. 39 дахь тал

зайлуулах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн засрал хүмүүжилд тухайн гэмт хэрэг үйлдэх үедээ оршин сууж байсан нутгийн орчин нөхцөл муугаар нөлөөлөх буюу гэмт хэрэг үйлдсэн этгээд тухайн нутагтаа байх нь нийгмийн бусад хэсэгт зохисгүй муу нөлөө үзүүлнэ гэж үзсэн үед оногдуулдаг байжээ. Энэхүү ялыг ялтан засран хүмүүжихэд нийгмээс тусгаарлан хорих ял оногдуулах шаардлагагүй гэж үзвэл үндсэн ялын чанартай хэрэглэдэг бол нэмэгдэл ял болгон оногдуулсан тохиолдолд үндсэн ялыг эдэлж дууссаны дараа эдлүүлдэг. Мөн нутаг зайлуулах ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан этгээд, 8 хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулахыг хориглодог бөгөөд хоёр жилээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар оногдуулдаг зэрэг нь Нутаг зааж суулгах ялтай ижил юм.

Мөн 1960 оны 170-р тогтоолд "Нийгэмд аюултай гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд олон нийтийн дунд хүмүүжин засарч чадах хүмүүсийг хамт олных нь хүсэлтийг үндэслэн хорих ял эдлүүлэхгүйгээр тэдний даалтад өгч байдаг журмыг тогтоох нь зүйтэй"⁴⁴ гэж заасан нь хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэх хууль зүйн үндэслэл бүхий баримт бичиг болж байгаа юм.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуульд энэ нэршлээрээ томъёологдсон бөгөөд үүнээс өмнө Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд гэрийн хорио ял, зорчих эрхийг хязгаарлах ял зэрэг нэршлээр орж байжээ. Нэр томъёоны хувьд гэрийн хорио, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах ял гэх мэтчилэн олон янзаар нэрлэн бичиж байгаа асуудал байгаа ба хууль зүйн нэр томъёоны хувьд дээрх электрон хяналтыг хэрэгжүүлэх ялын нэршлийг нэг мөр болгох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.5-р зүйлд ялын нэгэн төрөл болж ирсэн юм. Энэхүү ял нь манай улсын эрүүгийн хууль тогтоомжид урд өмнө тусгагдаж байгаагүй ялын нэн шинэ төрөл юм.

Эрүүгийн шинэ хуульд ялын шинэ төрөл, түүнийг хэрэгжүүлэх, хорих ялыг гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, үйлдлийн арга, сэдэл, зохион байгуулалт, оролцооноос хамааран ялгамжтай оногдуулах, түүнчлэн нийгмийн хор аюул бага, болгоомжгүй байдлаар болон анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихоос өөр төрлийн ялаар шийтгэж, тэднийг нийгэмшүүлэх, нийгэм, сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны хүрээнд засан хүмүүжүүлэх зорилготойгоор нийтэд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх, шаардлагатай тохиолдолд улс төрийн болон нийгэм, эдийн засгийн эрхэнд

⁴⁴ Т.Дэндэв. "БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн тухай асуудал". УБ., 1975. 31 дэх тал

хязгаарлалт хийх, зорчих эрхийг хязгаарлах зэргээр эдийн засгийн хувьд чирэгдэл багатай ялыг оногдуулахыг зорьсон байна⁴⁵.

⁴⁵ Б.Нямгомбо. "Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага". <http://criminology.mn>

1.3. Зорчих эрхийг хязгаарлах ялын эрх зүйн зохицуулалт

2017 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага нь ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэх ба зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино гэжээ. Ялын үндсэн төрөл болох зорчих эрхийг хязгаарлах ялыг гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг хэлнэ гэж тодорхойлжээ.

Зорчих эрхийг хязгаарлах ялын зохицуулалтыг Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулсан байна.⁴⁶

Зорчих эрхийг хязгаарлах ялыг гүйцэтгэх нийтлэг үндэслэл:

Ахлах шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн хүлээж авна. Ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхийн тогтоол, магадлалыг тоо бүртгэлд оруулан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргаж, ажлын 3 өдрийн дотор тойрог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид хуваарилж, энэ тухай прокурорт мэдэгдэнэ. Шийдвэр гүйцэтгэгч тогтоолыг хүлээн авсан даруйд ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлэх бөгөөд ялтан тус бүрд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, ялтан ял эдлүүлэх журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын хувийг прокурорт 5 хоногийн дотор хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд өөр орон нутагт оршин суух эсхүл торгох ял шийтгүүлсэн хуулийн этгээдийн ажил хэргээ байнга явуулдаг, удирдах байгууллага болон түүний эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн харьяаллаар шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр хувийн хэргийг, албан бичгийн хамт Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд хүргүүлж, прокурорт мэдэгдэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч нь ял эдэлж дууссан тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг үндэслэн тухайн ялтны ялыг үргэлжлүүлэн эдлүүлнэ.

⁴⁶Б.Баясгалан. Гадаадын зарим улсын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: инноваци, чиг хандлага” судалгааны тайлан

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтыг ялтан, эрх бүхий ажилтан, албан тушаалтан, иргэнээс тайлбар, тодорхойлолт, баримт бичиг гаргуулан авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг болон түүнд холбогдох баримт бичигтэй танилцах, шалгах, ялтныг биечлэн болон цахимаар шалгах, санал, тогтоол гаргах, ялтантай уулзах, тэмдэглэл үйлдэх, тоо бүртгэл хөтлөх, шаардлагатай байгууллага, албан тушаалтантай хамтран шалгалт хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирсэн зөрчлийн дохиог ирсэн даруйд хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ. Шийдвэр гүйцэтгэгч ирүүлсэн зөрчлийг биечлэн шалгаж, шалтгаан, нөхцөлийг тогтооно. Шийдвэр гүйцэтгэгч биечилсэн хяналтыг өдөр, шөнийн аль ч цагт явуулж болно. Шийдвэр гүйцэтгэгч ялтан биечлэн, эсхүл бусдаар дамжуулан шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, эсхүл зөрчихийг завдсан талаар хүн, хуулийн этгээдээс мэдээлэл авч болно.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, ахлах шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа хууль, журамд заасны дагуу явагдаж байгаа эсэхэд дараах байдлаар хяналт тавина. Үүнд:

1. Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь ялтны хувийн хэрэгтэй сар бүр танилцаж, хяналт тавина;

2. Эрх бүхий албан тушаалтан нь шаардлагатай тохиолдолд хувийн хэрэгтэй хэдийд ч танилцаж болно;

3. Эрх бүхий албан тушаалтан нь удирдах ажилтнаас хувийн хэрэгтэй танилцсан тухай тэмдэглэлийг хөтөлж, шаардлагатай тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгах үүргийг шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгчид бичгээр өгч, биелэлтийг тооцон заавар, зөвлөмжөөр ханган ажиллана;

4. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс ирүүлсэн хувийн хэрэг, холбогдох материалын үндэслэлтэй эсэхийг хянаж, ажлын 3 хоногийн дотор харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст буцаах, эсхүл шилжүүлэх арга хэмжээг авна;

5. Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгчээс гаргасан санал, хувийн хэрэгтэй танилцаж, саналаа хууль, журамд заасан хугацаанд үндэслэлтэй гаргасан эсэх болон хувийн хэргийн бүрдлийг хянана;

6. Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын улсын хилээр гарах эрхийг хязгаарлах, түр цуцлах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлж байгаа эсэхэд хяналт тавина;

7. Ахлах шийдвэр гүйцэтгэгч улсын хилээр гарах эрхийг хязгаарласан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтнуудын бүртгэлийг прокурортой улирал бүр тулгалт хийнэ.

Шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоолыг хүлээн авмагц зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хэрэглэх тоног төхөөрөмжийн болон ял эдлүүлэх нөхцөлийн талаарх саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчид танилцуулна.

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд сард нэгээс доошгүй удаа биечилсэн хяналт тавьж, тэмдэглэл үйлдэн хяналтын хувийн хэрэгт хавсаргана. Шийдвэр гүйцэтгэгч биечилсэн хяналтыг тавих бөгөөд ажлын бус өдөр, эсхүл шөнийн цагаар явуулах тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

Шийдвэр гүйцэтгэгч орон нутгийн алслагдмал газарт ял эдэлж буй ялтны талаар мэдээллийг Цагдаагийн байгууллагад хандан шалгуулна. Цагдаагийн байгууллагын албан тушаалтан нь заасан мэдээллийг шалгаж, холбогдох материалыг тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.

Шийдвэр гүйцэтгэгч ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, ял эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

Биечилсэн болон цахим хяналтаар илэрсэн зөрчлийг ялтанд танилцуулж, зөрчлийн акт, тэмдэглэл үйлдэнэ.

Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн, прокурорын болон тодорхой ажил, үйлчилгээ гүйцэтгэх, үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрлийг олгосон байгууллага, албан тушаалтан хуульд заасан чиг үүргийн хүрээнд тус тус хяналт тавина.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн үйл ажиллагаанд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангана.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх:

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах тохиолдолд түдгэлзүүлж, түдгэлзүүлэх үндэслэл арилмагц үргэлжлүүлэн гүйцэтгэнэ:

1. Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ялаас бусад хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих тухай саналаа прокурорт гаргасан, эсхүл прокурор энэ тухай дүгнэлтээ шүүхэд хүргүүлсэн;

2. Ялтан ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлсан, нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон;

3. Ял шийтгүүлсэн хуулийн этгээд татан буугдах, эсхүл өөрчлөн байгуулагдах ажиллагааны үед;

4. Ял шийтгүүлсэн хуулийн этгээдэд холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэсэн;

5. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсаныг нотлох эмч нарын комиссын дүгнэлт гарсан;

6. Нийтэд тустай ажил хийх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан жирэмсэлсэн бол төрөхөөс өмнөх 60 хоног, төрснөөс хойш 1 жил хүртэл хугацаагаар;

7. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас ял эдлүүлэх боломжгүй болсон;

8. Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтны гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай ганц хүн нь хүндээр өвчилсөн, эсхүл бусад хүндэтгэх шалтгаанаар ял эдлүүлэх боломжгүй бол 3 сар хүртэл хугацаагаар;

9. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан байнга оршин суугаа газраас бусад газарт 3 сараас дээш хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай болсон.

Шийдвэр гүйцэтгэгч дээрх үндэслэл тогтоогдсон тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан 5 хоногийн дотор хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ. Прокурор шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авмагц түдгэлзүүлэх үндэслэлийг хянаж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэж, тогтоол гаргана. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл арилаагүй тохиолдолд дахин нэг удаа 3 сар хүртэл хугацаагаар сунгах эсэхийг шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн прокурор шийдвэрлэнэ.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны үүрэг:

1. Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэх;

2. Шийдвэр гүйцэтгэгч, техникийн ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

3. Шүүхээс тогтоосон зорчихыг хязгаарласан газарт зорчихгүй байх;

4. Шийдвэр гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр оршин суугаа газар, ажлын байраа өөрчлөхгүй байх;

5. Шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирэх, ял эдлүүлэхтэй холбогдсон асуудлаар амаар болон бичгээр тайлбар гаргах;

6. Тогтоосон журмын дагуу зөөврийн хяналтын төхөөрөмжийг биедээ байнга авч явах, бүрэн бүтэн байдлыг нь хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах, хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

7. Хувийн бичиг баримтаа биедээ авч явах;

8. Ял эдэлж дуусмагц хяналтын тоног төхөөрөмжийг шийдвэр гүйцэтгэгчид бүрэн бүтэн хүлээлгэн өгөх.

Түүнчлэн ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй.

Ялтан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны талаарх гомдлоо шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтан, эсхүл прокурорт гаргана. Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан хууль тогтоомжид заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ. Ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож болно.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх журмыг зөрчих, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих:

Дараах тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг зөрчсөнд тооцно:

1. Хуульд заасан үүргээ биелүүлээгүй;

2. Техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагааг сарниулсан;

3. Зөрчлийн тухай хуульд заасан нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил үйлдэж, шийтгүүлсэн;

4. Техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн;

Дараах тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөнд тооцно:

1. Энэ хуульд заасан үүргээ 3 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа биелүүлээгүй;

2. Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн;

3. Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, шийдвэр гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр оршин суугаа газар, ажлын байраа өөрчилсөн зэрэг зөрчлийг давтан гаргасан;

4. Шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн;

5. Техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн.

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг зөрчсөн ялтанд дахин зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар сануулж, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх ярилцлага хийж, тэмдэглэл үйлдэнэ. Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А-234/А/103 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-аар зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих болон мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Энэ журамд зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд дараах байдлаар хяналт тавихаар зохицуулсан байна. Үүнд:

Нэг. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлбэр:

а. Хяналтыг ялтан, эрх бүхий ажилтан, албан тушаалтан, иргэнээс тайлбар, тодорхойлолт, баримт бичиг гаргуулан авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг болон түүнд холбогдох баримт бичигтэй танилцах, шалгах, ялтныг биечлэн болон цахимаар шалгах, санал, тогтоол гаргах, ялтантай уулзах, тэмдэглэл үйлдэх, тоо бүртгэл хөтлөх, шаардлагатай байгууллага, албан тушаалтантай хамтран шалгалт хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

б. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, ахлах шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа хууль, журамд заасны дагуу явагдаж байгаа эсэхэд дараахь байдлаар хяналт тавина:

-ахлах шийдвэр гүйцэтгэгч нь ялтны хувийн хэрэгтэй сар бүр танилцаж, хяналт тавина;

-эрх бүхий албан тушаалтан нь шаардлагатай тохиолдолд хувийн

хэрэгтэй хэдийд ч танилцаж болно;

-хяналт тавих албан тушаалтан нь удирдах ажилтнаас хувийн хэрэгтэй танилцсан тухай тэмдэглэлийг хөтөлж, шаардлагатай тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгах үүргийг шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгчид бичгээр өгч, биелэлтийг тооцон заавар, зөвлөмжөөр ханган ажиллана;

-хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь харьяалалын дагуу аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс ирүүлсэн хувийн хэрэг, холбогдох материалын үндэслэлтэй эсэхийг хянаж, ажлын 3 хоногийн дотор харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст буцаах, эсхүл шилжүүлэх арга хэмжээг авна;

-ахлах шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгчээс гаргасан санал, хувийн хэрэгтэй танилцаж, саналаа хууль, журамд заасан хугацаанд үндэслэлтэй гаргасан эсэх болон хувийн хэргийн бүрдлийг хянана;

-ахлах шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын улсын хилээр гарах эрхийг хязгаарлах, түр цуцлах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлж байгаа эсэхэд хяналт тавина;

-ахлах шийдвэр гүйцэтгэгч улсын хилээр гарах эрхийг хязгаарласан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтнуудын бүртгэлийг прокурортой улирал бүр тулгалт хийнэ.

в. Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.

г. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.

д. Шийдвэр гүйцэтгэгч ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, ял эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

Хоёр. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх нийтлэг үндэслэл:

1. Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын хувийг прокурорт 5 хоногийн дотор хүргүүлнэ.

2. Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд өөр орон нутагт оршин суух эсхүл торгох ял шийтгүүлсэн хуулийн этгээдийн ажил хэргээ байнга явуулдаг, удирдах байгууллага болон түүний эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн харьяаллаар шилжүүлэх эсэх асуудлыг

шийдвэрлүүлэхээр хувийн хэргийг, албан бичгийн хамт Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд хүргүүлж, прокурорт мэдэгдэнэ.

3. Шийдвэр гүйцэтгэгч нь ял эдэлж дууссан тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг үндэслэн тухайн ялтны ялыг үргэлжлүүлэн эдлүүлнэ.

Гурав. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны нөхцөл, журам:

1. Шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоолыг хүлээн авмагц зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хэрэглэх тоног төхөөрөмжийн болон ял эдлүүлэх нөхцөлийн талаарх саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчид танилцуулна.

2. Ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтанд хэрэглэх тоног төхөөрөмжийг тогтоох бөгөөд энэ тухай тогтоол гаргаж, хувийг прокурорт хүргүүлнэ.

3. Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг үндэслэн техник хяналт хариуцсан ажилтан суурин болон хөдөлгөөнт хяналтын тоног төхөөрөмжийг ялтны бие, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, шаардлагатай бусад газарт суурилуулж, хяналтын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон ялтанд байнгын хяналт тавина.

3. Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хөдөлгөөнт болон суурин хяналтын тоног төхөөрөмжийг эвдэж, гэмтээсэн тохиолдолд засвар үйлчилгээ хийх болон түүнтэй холбогдон гарах бусад зардлыг нөхөн төлүүлэх талаар танилцуулна.

4. Шийдвэр гүйцэтгэгч тухайн ялтанд холбогдох шүүхийн шийдвэр болон бусад шаардлагатай мэдээллийг техникийн хяналтын ажилтанд гаргаж өгнө.

5. Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирсэн зөрчлийн дохиог ирсэн даруйд хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаархи мэдээллийг хүргүүлнэ.

6. Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд сард нэгээс доошгүй удаа биечилсэн хяналт тавьж, тэмдэглэл үйлдэн хяналтын хувийн хэрэгт хавсаргана.

7. Шийдвэр гүйцэтгэгч биечилсэн хяналтыг өдөр, шөнийн аль ч цагт явуулж болох ба ажлын бус өдөр, эсхүл шөнийн цагаар явуулах тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

8. Шийдвэр гүйцэтгэгч орон нутгийн алслагдмал газарт ял эдэлж буй ялтны талаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, эсхүл зөрчихийг завдсан талаар хүн, хуулийн этгээдээс мэдээлэл авч болно. мэдээллийг Цагдаагийн байгууллагад хандан шалгуулна.

9. Цагдаагийн байгууллага нь мэдээллийг шалгаж, холбогдох материалыг тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирүүлнэ.

10. Биечилсэн болон цахим хяналтаар илэрсэн зөрчлийг ялтанд танилцуулж, зөрчлийн акт, тэмдэглэл үйлдэнэ.

11. Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөх болон өөрчлөх талаар гаргасан ялтны хүсэлт, холбогдох баримтыг үндэслэлтэй эсэхийг хянаж, саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчид танилцуулна.

12. Шийдвэр гүйцэтгэгч хохирлыг нөхөн төлүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр /акт/-ийг үндэслэн тухайн гэм буруутай этгээдэд мэдэгдэл хүргүүлэх ба заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

Мэдээллийн цахим сан бүрдүүлэх, ашиглах:

Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны талаар дараах төрлийн мэдээллийн цахим санг бүрдүүлнэ:

1. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн цахим бүртгэл, мэдээллийн сан;

2. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээдийн цахим хяналтын мэдээллийн сан.

Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст тойргийн шийдвэр гүйцэтгэгч нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны тоо бүртгэлийг хөтлөхдөө мэдээллийн санд хувийн хэргийг цахим хэлбэрээр бүртгэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч тухайн ялтанд холбогдох шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор цахим хувийн хэрэг нээж, мэдээллийн санд бүртгэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч цахим хувийн хэргийн баяжилт, шилжилт, хөдөлгөөний мэдээллийг тухай бүр тогтмол бүртгэнэ.

Аймаг, нийслэлийн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн цахим тоо бүртгэл хөтлөлт, мэдээллийн сан бүрдүүлэлтэд тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга, ахлах шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих бөгөөд улсын нэгдсэн цахим тоо бүртгэл хөтлөлт, мэдээллийн сан бүрдүүлэлтэд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангана.

Цахим хяналтын нэгж нь зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын мэдээллийн сан, хөдөлгөөний тэмдэглэл /маршрут/-ийн сан болон зөрчлийн сан үүсгэн, тасралтгүй хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, судалгаа шинжилгээ хийх зорилгоор хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтны мэдээллийн санг ашиглаж болох бөгөөд мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж хамтран ажиллана.

Мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд гаргаж өгнө.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны мэдээллийн сан нөөцлөлт, сүлжээний хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг мэдээлэл технологийн нэгж хариуцан ажиллана. Мэдээллийн санд хандах нууц үгийн нууцлал, хамгаалалтыг хандах эрх бүхий алба хаагч өөрөө хариуцна.

Хорихоос өөр төрлийн ялын бүртгэлийн системд нэвтрэх эрх бүхий алба хаагч ажлаас чөлөөлөгдсөн, шилжин томилогдсон тохиолдолд мэдээлэл технологийн нэгжид даруй мэдэгдэж, түүний системд нэвтрэх эрхийг хүчингүй болгох ба тухайн ажилд томилогдсон алба хаагчид нэвтрэх нэр, нууц үгийг шинээр олгоно.

Мэдээллийн санд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны мэдээллийг энэ журамд заасан хугацаанд бүртгээгүй, баяжилт, шилжилт хөдөлгөөнийг хийгээгүй, хяналт тавиагүй нь тогтоогдвол тухайн албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.

Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны талаар тоо бүртгэл хөтөлж, мэдээ, тайлан гаргах:

Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн талаарх тоо бүртгэлийг аймаг, нийслэлд тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл, цахим санг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлж, хяналт тавина.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн талаарх нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээ, тайлан тэнцлийг нэгтгэх бөгөөд тухайн газар, хэлтсийн дарга хяналт тавина.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн шилжилт хөдөлгөөн, ялын биелэлтийн талаарх мэдээ, судалгааг сар бүр гарган, харьяа прокурорын газар болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд хүргүүлнэ.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс ирүүлсэн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн шилжилт хөдөлгөөн, ялын биелэлтийн талаарх мэдээ, судалгааг нэгтгэж, сар бүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага болон Улсын Ерөнхий прокурорын газарт тус тус хүргүүлнэ.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэж буй ихэнх улс орнуудын хувьд энэхүү ялын үр нөлөөтэй тал нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хэрэглэх замаар түүнд зөв амьдралын хэвшил олох, хүмүүжих, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зорилгыг хангах хамгийн боломжит нөхцөл гэж үзэж байгаа юм.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хэрэглэх зорчих эрхийг хязгаарлалтын хөтөлбөр гэрийн хяналтын төхөөрөмж, гар хөл бугуйн гав, GPS хяналтын төхөөрөмж, согтууруулах мансууруулах бодис хэмжигч, дуу хоолой танигч төхөөрөмж зэрэг багтдаг байна.⁴⁷ Ихэвчлэн гэрийн хорионд байлгах арга хэмжээг хэрэглэдэг. Ингэхдээ идэвхтэй болон идэвхгүй хяналтын хэлбэрийг шүүхээс сонгодог байна. Мөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд шүүхийн өмнөх болон ял оногдуулах, шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд цахим хяналтын хөтөлбөрийг таслан сэргийлэх арга хэмжээ хэлбэрээр хэрэглэдэг ажээ.⁴⁸

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэхийн давуу талыг дараах байдлаар харж байна. Үүнд:

- Улс орны эдийн засагт нөлөөлж буй санхүүгийн дарамт нөлөөллийг багасгаж буй нь хамгийн том давуу тал гэж үзэж байгаа юм. Зорчих эрхийг хязгаарлах ял нь нэг ялтны хувьд гаргаж буй зардал нь 5.50-10 ам.долларын хооронд байдаг бол харин хяналтын төв нь өдөртөө 100-160 ам.долларын зардал гаргадаг байна.⁴⁹ Электрон хяналтын төхөөрөмж хэрэглэх, зорчих эрхийг хязгаарлах нь өсвөр насны ял шийтгүүлсэн хүмүүсийн мөнгийг ч мөн хэмнэх боломжтой гэж үздэг ба шүүхээс тухайн этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан энэхүү арга хэмжээг хэрэглэхдээ тодорхой хөнгөлөлт үзүүлж болдог байна.⁵⁰

- Судлаачдын судалгаагаар зорчих эрхийн хязгаарлалт дор гэртээ болон сургуульдаа үргэлжлүүлэн байж гэр бүл, хамт олны дунд хүмүүжиж байгаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүмүүсийн нийгэмшил, төлөвшлийг олж буй байдал нь бусад төрлийн ял, эрүүгийн хариуцлагын арга хэмжээтэй харьцуулахад өндөр хувьтай байгааг харуулж байна. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн өсвөр насны хүмүүсийн дунд дахин гэмт хэрэг үйлдэж буй байдал нь АНУ-д 3 хувьтай⁵¹ байсан бол 2002 онд АНУ-н Техас мужид энэхүү төрлийн ялаар шийтгүүлсэн 242 өсвөр насны хүний дунд судалгаа явуулахад хөтөлбөр амжилттай хэрэгжсэн хувь нь 85 хувь байсан байна.⁵² Харин энэхүү судалгааг

⁴⁷ National Law Enforcement and Corrections Technology Center Bulletin, Keeping Track of Electronic Monitoring, Oct. 1999, <http://www.justnet.org/Lists/JUSTNET%20Resources/Attachments/859/Elec-Monit.pdf> (last visited June 7, 2010).

⁴⁸ ALA. CODE § 12-15-127 (2010); FLA. STAT. § 985.27 (West 1010).

⁴⁹ Jeff Abell, Juvenile Offenders Housing Costs Spike: Board Explores Pulling Juveniles from Lee County Center, THE HAWK EYE, Mar. 5, 2010 available at 2010 WLNR 4744738; Rex Smith, A Useful, Imperfect Tool Despite the Tragic Shooting of a 5-Year-Old, GPS Monitoring has a Proven Track Record, BALTIMORE SUN, Oct. 23, 2009 at 21A, available at 2009 WLNR 21055672

⁵⁰ Adam Folk, Courts Official Reports Threats Incident Followed Hearing for Teens, AUGUSTA CHRONICLE, May 14, 2010 at B01, available at 2010 WLNR 10982345.

⁵¹ OJJDP Model Programs Guide, Home Confinement/Electronic Monitoring, www.dsgonline.com

⁵² Tarrant County, Immediate Home Detention – Electronic Monitoring, www.tarrantcounty.com

умард Каролина мужид явуулахад амжилттай хэрэгжсэн хувь нь 75 хувь байжээ.⁵³

- Ял шийтгүүлсэн этгээдийг тогтмол байнгын хяналтад байлгах боломжтой. Электрон хяналтын төхөөрөмж, GPS төхөөрөмжид суурилсан байршил тодорхойлох хяналт нь ял шийтгүүлсэн этгээдийн урьдчилан тогтоосон маршрут, байршлаас гарахгүй байх хяналтын нөхцөлийг зөрчихгүй байх үүргийг хэрэгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлдэг.⁵⁴ Мөн энэхүү хяналт нь хяналтад байгаа этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэрэмжлэхээс гадна өөр бусад хэрэгт оролцоогүй болохыг нь нотлох "алиби"-ийн үүргийг мөн гүйцэтгэдэг байна.⁵⁵ Мөн зорчих эрх нь хязгаарлагдсан өсвөр насны ялтанд сургуульдаа цаг тухай бүрд нь очиж байгаа эсэх сургалтын байгууллагад хамрагдаж байгаа эсэхийг ч гэсэн мөн давхар хянах боломжийг бүрдүүлдэг ажээ.⁵⁶

Дээрх давуу талуудаас гадна бас дараах сул талууд байж болох талаар судлаачид тэмдэглэж байна. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн болон түүний гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын санхүүгийн байдлаас энэхүү арга хэмжээг хэрэглэх эсэх нь хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл ялгаварлал бий болж байна гэж үздэг хүмүүс бий. Төхөөрөмжийн ашиглалтын зардал нь өдөр тутамдаа гарч байдаг. Үүнийг нь төлөх үүрэг хариуцлага нь ихэвчлэн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид оноогдож байгаа юм.⁵⁷ Тухайлбал телефон утасны төхөөрөмж байрлуулах, шугамд холбуулах, уг телефон утасны төлбөрийг төлөхөөс авхуулаад төхөөрөмж суурилуулах, өдөр тутамд зай хураагуурыг цэнэглэх, шаардлагатай шинжилгээний зардал, төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд төлөх зардал зэрэг олон төрлийн зардлуудыг гаргадаг. Хэрэв ял шийтгүүлсэн өсвөр насны хүүхэд, түүний гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь дээрх зардлуудыг төлөх боломжгүй бол зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэх боломжгүй болох юм.

- Дохионы хязгаарлалт бүхий орчин болоод дохио долгионы бүсээс гарсан тохиолдолд дохио сарних, дамжуулалт тасрах зэрэг асуудал үүсдэг.

⁵³ Tarrant County, Immediate Home Detention – Electronic Monitoring, www.tarrantcounty.com

⁵⁴ Rex Smith, A Useful, Imperfect Tool Despite the Tragic Shooting of a 5-Year-Old, GPS Monitoring has a Proven Track Record, BALTIMORE SUN, Oct. 23, 2009 at 21A, available at 2009 WLNR 21055672.

⁵⁵ Justin Fenton, Lawyers for Teen to Call on GPS Firm Alibi Suggested in Case Where 5-Year-Old was Shot, BALTIMORE SUN, Sept. 4, 2009 at 3A, available at 2009 WLNR 17376903; Michelle Hunter, Four Arrested in Fatal Chase, NEW ORLEANS TIMES PICAYUNE, May 20, 2009 at 1, available at 2009 WLNR 9568985.

⁵⁶ Laura Maggi, Arrests Show Limits of Ankle Bracelets, NEW ORLEANS TIMES PICAYUNE, Mar. 14, 2009 at 1, available at 2009 WLNR 4861958; Michelle Casady, Staying on top of truancy, THE EAGLE, Jan. 20, 2010, available at 2010 WLNR 1213591.

⁵⁷ Newport News Department of Juvenile Services, Electronic Monitoring Program, <http://www.nngov.com/juvenile-services/resources/electronic-monitoring-program>

- Судлаачдын санааг зовоож буй асуудал нь цахим гав, электрон хяналтын төхөөрөмж зүүж явах нь ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд нийгмээс ичих, сэтгэл санааны дарамтад орох зэрэг сэтгэл зүйн асуудал болж байна.⁵⁸ АНУ-ын Монрое, Ниагара, Онодага зэрэг хотуудыг хамруулан зорчих эрхийг хязгаарлах, цахим гав, цахим хяналтын хөтөлбөрт хамрагдсан 115 өсвөр насны хүмүүсийг хамруулсан судалгааг явуулахад 64 хувь нь хөтөлбөрийг бүрэн дуусахаас өмнө төхөөрөмжийг эвдлэх зэргээр салгаж авсан байна.⁵⁹ Мөн цахим гав зүүсэн цагаас эхлэн өсвөр насны хүмүүс нь өөрийгөө гэмт хэрэгтэн гэж мэдрэх, ийм байдлаар биеэ авч явах байдал ч ажиглагджээ.⁶⁰

Зорчих эрхийн хязгаарлалтын хөтөлбөрүүд нь олон сул талтай боловч эдгээрийг бууруулах арга замууд бий гэж үзэж байна. Цаашдаа сэтгэл хөдлөл, сэтгэл зүйд үлдэх үр нөлөөг нь бусад арга хэмжээнийхтэй харьцуулан судлах шаардлагатай. Зөрчил гаргагчдад үеийнхэн болон харгалзагчид нь тэгш бус ханддаггүй бөгөөд цахим хяналтын төхөөрөмжүүд муу зан үйл хийхээс нь урьдчилан сэргийлж, үр дагаврыг нь байнга сануулж байдгийг нэгэн судалгаанд тэмдэглэжээ.⁶¹ GPS хяналтын төхөөрөмжийн зай хураагуурын тэжээл бага байх үед өсвөр насны зөрчил гаргагчийн өмгөөлөгч нь түүнд тэнсэнгийн хяналтын ажиглагчдаа энэ талаар нэн даруй мэдэгдэх ёстойг нь байнга сануулахаас гадна шинэ зай хураагуур авах, эсхүл шинэ GPS төхөөрөмж захиалах ёстойг зөвлөх шаардлага үүсдэг байна.⁶² Төлбөрийн чадваргүй гэр бүлүүдийн хувьд АНУ болоод түүний муж, орон нутаг, бүс нутгийн удирдлагууд, төрийн захиргааны байгууллагууд нь холбогдох бүх зардлыг гаргаж уг хөтөлбөрийг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Хэрвээ татварын мөнгө зорчих эрхийг хязгаарлах хөтөлбөрийг бүхэлд нь санхүүжүүлж хүрэлцэхгүй байвал АНУ-ын муж, орон нутаг, бүс нутгийн удирдлагууд орлого багатай гэр бүлүүдэд хөнгөлөлт олгох, төлбөрийн чадваргүй өсвөр насны ялтанд нийтэд тустай ажил хийж төлбөрийг барагдуулах сонголт өгөх боломжтой байдаг ажээ. Тухайлбал Сасексийн гүнлигт , Нью Жерсид төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөл юм уу нийтэд тустай ажил хийхийг сонгох боломж олгодог. Жилдээ нийтдээ \$50,000-оос бага цалинтай, ажилгүй, тэтгэмж авдаг эцэг эх юм уу асран хамгаалагчтай бол өдөрт \$5 төлөх, эсхүл шийтгүүлсэн этгээдээр өдөрт 5 цагийн нийтэд тустай ажил хийлгэх боломжтой.

⁵⁸ Michael T. Charles, *Research Notes: Juveniles on Electronic Monitoring*, 5 JOURNAL OF CONTEMPORARY CRIMINAL JUSTICE ONLINE 165, 167 (1989).

⁵⁹ Michael T. Charles, *Research Notes: Juveniles on Electronic Monitoring*, 5 JOURNAL OF CONTEMPORARY CRIMINAL JUSTICE ONLINE 165, 167 (1989).

⁶⁰ Michelle Casady, *Staying on top of truancy*, THE EAGLE, Jan. 20, 2010, available at 2010 WLNR 1213591.

⁶¹ John F. Tewey, *Maryland Task Force to Study Criminal Offender Monitoring by Global Positioning Systems*, Final Report to the Governor and General Assembly (Dec. 31, 2005), available at http://www.dpscs.state.md.us/publicinfo/publications/pdfs/GPS_Task_Force_Final_Report.pdf/.

⁶² Julie D. Bowden et al., *Issues Pertaining to the Juvenile Defendant at Trial*, MA-CLE § 11.2.1 (2009)

Жилд \$50,000-\$75,000 цалинтай эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч өдөрт \$10 төлөх юм уу шийтгүүлсэн этгээдээр 10 цагийн нийтэд тустай ажил хийлгэх, \$100,000-оос дээш хэмжээний цалинтай эцэг эх, харгалзан дэмжигч өдөрт \$20 төлөх юм уу зөрчил гаргагчаар хорин цагийн нийтэд тустай ажил хийлгэх боломжтой. Зорчих эрхийг хязгаарлах хөтөлбөрт тэнцсэн ямар ч өсвөр насны хүнд гагцхүү гэр бүлийнх нь эдийн засгийн төлөв байдлыг харгалзан уг хөтөлбөрт хамруулахаас татгалзаж болохгүй.⁶³

⁶³ Joe Mosczynski, Sussex will Charge Parents a Fee for Youths' Home Confinement, THE STAR-LEDGER, Apr. 18, 2010 at 29, available at 2010 WLNR 8034412.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРОНД ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1. Зорчих эрхийг хязгаарлах ялтай холбогдох олон улсын хэм хэмжээ

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 10-р сарын 14-ний 45/110-р тогтоолоор батлагдсан Нэгдсэн Үндэсний байгууллагын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм /Токиогийн дүрэм/ /цаашид Жишиг дүрэм гэх/ хэмээх олон улсын баримт бичгийн 1.5-д Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрхийн зөрчил гаргагчийг нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрхийн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна. 2.1-д Энэ дүрмийн хамаарах заалтууд нь мөрдөн байцаалтад шүүхийн хэлэлцүүлэг болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл зэрэг байцаан шийтгэх эрүүгийн бүх шатны бүх этгээдүүдэд хэрэглэгдэнэ. Энэ дүрмийн зорилгоор тэдгээр этгээдүүд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэн байхаас үл хамааран “эрхийн зөрчил гаргагч” гэж нэрлэнэ гэж заасан ба хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх хүрээг шүүхийн өмнөх шатанд, шүүхийн шат ба тогтоол гаргах шат, шийтгэх тогтоол гарсны дараах шатанд гэж тус тус ангилсан байна.

Уг дүрмийн 6.1-д зааснаар Шүүхийн өмнөх шатанд “Тодорхой хэргийг мөрдөн шалгах хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцгой арга хэмжээ болгож хэрэглэх ёстой” гэж заасан байна.

Харин мөн дүрмийн 8.2-д шүүхийн ба тогтоол гаргах шатанд “Шийтгэх тогтоол гаргаж байгаа байгууллагууд хэргийг дараах байдлаар шийдвэрлэж болно.”

- а/ Сануулах, зэмлэх, буруушаах зэрэг аман арга хэмжээ;
- в/ Хариуцлагаас тэнсэн чөлөөлөх;
- с/ Иргэний эрхийг нь хасах;
- д/ Нэг удаагийн болон өдрийн торгуулиуд гэх мэт мөнгөн шийтгэлүүд, эдийн засгийн арга хэмжээнүүд;
- е/ Хөрөнгө хураах болон эд хөрөнгө өмчлөх эрхийг нь хасах тогтоол;
- f/ Хохирогчид эд хөрөнгийг нь буцааж өгөх болон хохирол төлөх тогтоол;
- g/ Тэнсэн шийтгэл болон шийтгэлийг хойшлуулах;
- h/ Хорихоос тэнсэн суллах болон шүүхийн хяналт;
- i/ Нийгмийн тусгай хөдөлмөр хийлгэх тухай тогтоол;
- j/ Тодорхой газарт заавал ирж бүртгүүлж байх болзол тогтоо;

к/ Гэрийн хорио;

л/ Хорихтой холбоогүй бусад арга хэмжээнүүд;

м/ дээр дурдсан арга хэмжээнүүдийг хослуулан хэрэглэх гэж заасан ба үүнд гэрийн хорио гэж орж ирсэн нь зорчих эрхийг хязгаарлах ялын нэгэн төрлийг тусгаж өгсөн байгаа юм.

Жишиг дүрмийн V Хорихтой холбоогүй арга хэмжээг биелүүлэх нь гэсний 10.1-т Дахин хэрэг зөрчил үйлдэх явдлыг багасгах, архаг болохоос сэргийлэх, түүнийг нийгмийн амьдралд түргэн оруулахад туслах замаар түүнийг дахин хэрэгт орооцолдох магадлалыг бууруулахад хяналтын зорилго оршино. 10.2. Хэрэв хорихтой холбоогүй аль нэг арга хэмжээ нь хяналттай байна гэвэл тэр нь хуулиар тодорхойлогдсон тодорхой нөхцөлийн доор эрх бүхий байгууллагаар гүйцэтгэгдэнэ гэж тус тус зааж өгчээ. Энд шууд цахим гав, цахилгаан буюу электрон хяналтын төхөөрөмж, согтууруулах ундаа-мансууруулах бодис хэмжигч зэргийг хэрэглэх талаар шууд зааж өгөөгүй боловч дахин хэрэг зөрчил үйлдэх явдлыг багасгах, архаг болохоос сэргийлэх, дахин хэрэгт орооцолдох магадлалыг бууруулахад хяналтын зорилго оршино гэж зааж өгсөн явдал нь дээрх төхөөрөмжүүдийн тусламжтайгаар хяналт тавихтай зорилгын хувьд нийцэж байгаа бөгөөд цахим гав зэрэг төхөөрөмжийг хэрэглэх боломжийг санал болгосон байгаа юм.

Монгол Улсын хувьд энэхүү жишиг дүрэмд нэгдсэн бөгөөд Монгол Улсын Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх журамтай учир манай улс аль болох хорихоос өөр төрлийн ял хэрэглэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

2.2. Пост-Социалист орнуудын зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог

Эдүгээ пост социалист орнуудын хувьд зорчих эрхийг хязгаарлах ялын чиглэлээр дагнан судалсан судалгааны бүтээл, нэг сэдэвт зохиол ховор байна. Харин ОХУ-ын эрдэмтэд болох В. Н. Орлов, А. А. Павлова, В. В. Джужома нарын бүтээлүүдэд энэ талаар тусгагдсан байгаа боловч энэ нь нэлээдгүй хуучирсан, жишээ болгон авч үзэж байсан улсуудад зорчих эрхийг хязгаарлах ял хуульд нь байхаа больсон тохиолдлууд байна.⁶⁴ Судалгаанд тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн биш Киргизийнхээс бусад бүх улсын эрүүгийн хуулиудыг судалсан. Гүрж, Литва, Польш, Болгар улсууд ТУХН-т багтдаггүй учраас дээрх улсуудын хууль тогтоомжийг танин мэдэхүйн зорилгоор судалгаанд авч үзсэн.

Дурдагдсан улсуудын ихэнх нь ОХУ-ынхтай адил төсөөтэй эрүүгийн хуультайгаараа онцлог бөгөөд эрх чөлөө хязгаарлах төрлийн ял байгаа тохиолдолд ОХУ-ын Эрүүгийн хуулийн өмнөх шинэчилсэн найруулгатай төстэй юм (2009.12.27-ны № 377-ФЗ хуулийг батлах хүртэлх).

Бүгд Найрамдах Азербайжан улсын Эрүүгийн хуулийн⁶⁵ 42 дугаар зүйл нь 2011.05.31-ны хуулийн дагуу нэмэлт өөрчлөлт орж хасагдсан тул 42 дугаар зүйлийн дагуу тус улсад эрх чөлөөний хязгаарлалт нь ялын төрөл хэлбэр байхаа больсон юм. Бүгд Найрамдах Азербайжан Улсын Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйл нь эрх чөлөөг хязгаарлах нь шүүхээс гэм буруутайг тогтоосон шийдвэр гаргах үед 18 насанд хүрсэн байсан ялтныг нийгмээс тусгаарлалгүйгээр, хараа хяналтан доор тусгай байгууллагад байлгахыг хэлнэ. Эдүгээ эрх чөлөөг хязгаарлах ялын зарим зохицуулалтууд Азербайжаны Эрүүгийн хуулийн гагцхүү 70.5 дугаар зүйлд хуульчлагдсан. Уг зүйлийн дагуу шүүх тохирох шийтгэлийг өгөхдөө дараах үүргийг ногдуулах боломжтой: байнга оршин суудаг, сурдаг, ажилладаг газраа зан байдлыг хянадаг байгууллагад мэдэгдэлгүйгээр өөрчлөхгүй байх, тодорхой газруудад очихгүй байх, архи, мансууруулах болон хорт бодис, бэлгийн замын өвчний цуврал эмчилгээнд хамрагдах, гэр бүлээ эд зүйлээр тэтгэн дэмжих гэх мэт үүргийг хүлээлгэдэг. Шүүхээс ялтныг засан хүмүүжүүлэхэд нэмэр болохуйц өөр үүрэг даалгавар мөн ноогдуулж болно.

Бүгд Найрамдах Беларусь Улсын Эрүүгийн хуулийн⁶⁶ 55 дугаар зүйлд эрх чөлөөг хязгаарлах нь ялтанд эрх чөлөөг нь хязгаарласан үүрэг ногдуулах, ялыг биелүүлэх байгууллагуудаас хяналт тавихаар зохицуулсан байдаг. Эрх чөлөөг хязгаарлах ял нь нээлттэй төрлийн засан хүмүүжүүлэх чиглэлтэйгээр ногддог.

⁶⁴ Л.А.Барков, "Ограничение свободы в современном уголовном законодательстве стран СНГ" Вестник Челябинского государственного университета. 2012. №29 (289).Право.Вып.33.С.48-52.

⁶⁵ www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/43

⁶⁶ www.unodc.org

Гэм буруутай этгээдийн хувийн байдал, зан араншин, засарч хүмүүжих боломж, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, байнга оршин суух хаягтай, орон гэртэй эсэх зэргийг харгалзан шүүхээс нээлттэй төрлийн засан хүмүүжүүлэх байгууллага руу илгээхгүйгээр эрх чөлөөг хязгаарлах ял оногдуулж болно.

Бүгд Найрамдах Беларусь Улсын Эрүүгийн хуулийн 114.1-р зүйлд зааснаар эрх чөлөөг хязгаарлах ялыг 18 хүртэлх насны этгээдэд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар оногдуулдаг. Ял оногдуулах үед 18 насанд хүрээгүй этгээдэд эрх чөлөөг хязгаарлах ялыг нээлттэй төрлийн засан хүмүүжүүлэх байгууллагад өгөлгүйгээр оногдуулдаг бол 18 насанд хүрсэн этгээдэд нээлттэй төрлийн засан хүмүүжүүлэх байгууллагад өгөх буюу өгөлгүйгээр оногдуулдаг.

Бүгд Найрамдах Беларус Улсын Эрүүгийн хуулийн 5 дугаар хэсэг, 90 дүгээр зүйл, 3 дугаар хэсэг, 77 дугаар зүйлд зааснаар болзолтойгоор хугацаанаас нь өмнө тэнсэн суллахдаа шүүх ялтныг хохирогчоос уучлал гүйх, тогтоосон хугацаанд учирсан хохирлоо арилгах, хөдөлмөр эрхлэх юм уу сурах, архаг архичин, мансууруулах болон хорт зуршил, бэлгийн замын өвчний цуврал эмчилгээнд хамрагдах, оршин суух газраа хяналт явуулж буй байгууллагын зөвшөөрөлгүйгээр солихгүй байх, хувийн бусад шалтгаанаар 1 сараас илүү хугацаагаар бүс нутгаас (хотоос) гарахгүй байх, тухайн байгууллагадаа тогтмол хугацаанд бүртгүүлэхээр ирж байх, тодорхой хугацаа өнгөрсний дараа оршин суугаа газартаа байх, тодорхой газруудад зорчихгүй байхыг шаардах боломжтой байдаг. Беларусын Эрүүгийн хуулийн 80 дугаар зүйлд шүүх урьдчилан сэргийлэх хяналт тавих юм уу түүнийгээ хэрэгжүүлэхдээ тухайн хяналт тавигдсан этгээдээс дараах урьдчилан сэргийлэх хяналтын шаардлагуудыг биелүүлэхийг үүрэгдэж болдгоороо онцлогтой. Үүнд тодорхой газруудад зорчихгүй байх, тодорхой цагуудад өөрийн орон байрнаас гарахгүй байх, дотоод явдлын байгууллагад сардаа 1-4 удаа ирж бүртгүүлэх зэрэг хамаардаг байна.

Казакстаны Эрүүгийн хуулийн⁶⁷ 45 дугаар зүйлийн дагуу эрх чөлөөг хязгаарлахдаа шүүхээс түүний эрх чөлөөг хязгаарласан хугацаанд тодорхой шаардлагууд тавин, нийгмээс нь тусгаарлалгүйгээр 1-ээс дээш жил мэргэжлийн байгууллагын хяналт дор оршин суудаг газарт нь ялыг эдлүүлдэг. Шүүх эрх чөлөөг хязгаарлах ялыг ногдуулахдаа ялтанд дараах үүргүүдийг биелүүлэхийг үүрэгддэг. Үүнд байнга оршин суудаг, ажилладаг, сурдаг газраа мэргэжлийн байгууллагад мэдэгдэлгүйгээр солихгүй байх, тодорхой газруудаар зорчихгүй байх, сургууль болон ажлын чөлөөтэй цагаар оршин суудаг газраасаа гарахгүй байх, мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр газар нутаг руу явахгүй байх зэрэг үүргүүд хамаардаг. Шүүх нь эрх чөлөө хязгаарлах ял ногдуулсан

⁶⁷ www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/21

ялтанд түүнийг засан хүмүүжихэд нэмэр болох өөр бусад үүргүүдийн биелэлтийг шаардах боломжтой. Тухайлбал архи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бусад хорт бодис хэрэглэх зуршил, бэлгийн замын халдварт өвчний цуврал эмчилгээнд хамрагдах, гэр бүлдээ санхүүгийн болон эд хөрөнгийн туслалцаа дэмжлэг үзүүлэх гэх мэт. Казахстаны хууль тогтоогч нар эрх чөлөөг хязгаарлах ялын сул талуудын талаар хэдэн зүйлийг онцлон холбогдох өөрчлөлтийг хуульд оруулсан байдаг. Бүгд Найрамдах Казахстан Улсын 2011.11.09 -ний №490-IV ЗРК хуулиар эрх чөлөөг хязгаарлах ялыг байнга оршин суух газаргүй этгээдэд хэрэглэхгүй байхаар хуульчилсан байна.

Бүгд Найрамдах Молдав Улсын Эрүүгийн хуулийн⁶⁸ 62, 63 дугаар зүйл дэх ялын төрлүүдийн дотор эрх чөлөөний хязгаарлах ял нь хуульчлагдаагүй байгаа юм. Гэхдээ уг ялын зарим элементүүд нь мөн хуулийн 90 дүгээр зүйлд хуульчлагдсан байдаг. Үүнд болзолт ял шийтгэл хэлбэрээр хэрэглэн шүүхийн шаардлагаар ялтныг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр амьдарч буй газраа солихгүй байх, тодорхой газруудаар зорчихгүй байх, архидах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй хорт бодис хэрэглэх болон бэлгийн замын халдварт өвчний цуврал эмчилгээнд хамрагдах, тусгай эмчилгээний юм уу зөвлөх хөтөлбөрт хамрагдах замаар хэрцгий догшин зан авирыг бууруулах, хохирогчийн гэр бүлд эд хөрөнгийн туслалцаа үзүүлэх, шүүхийн шаардлагаар тогтоосон хугацаанд учирсан хохирлыг барагдуулахыг үүрэгдэж болдог.

Бүгд Найрамдах Тажикстан Улсын Эрүүгийн хуулийн⁶⁹ 54 дүгээр зүйлд зааснаар эрх чөлөөг хязгаарлах нь ялтныг нийгмээс тусгаарлахгүйгээр 1-5 жилийн хугацаатайгаар хяналт тавих нөхцөлтэйгөөр тусгай байгууллагад байлцуулахад оршино. Бүгд Найрамдах Тажикстан Улсын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлд зааснаар насанд хүрээгүй этгээдэд эрх чөлөөг хязгаарлах ялыг ногдуулдаггүй онцлогтой.

Туркменистаны Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд эрх чөлөөг хязгаарлах ялыг ялын төрөлд тусган хуульчлаагүй. Харин Эрүүгийн хуулийн 68 дугаар зүйлийн дагуу шүүх болзолт ял тулгахдаа ялтанд тодорхой үүргийг биелүүлэхийг шаардаж болдог ажээ. Тухайлбал учирсан хор уршгийг арилгах, ажил хийх юм уу суралцах, болзолт ял эдэлж буй этгээдийн зан байдалд хяналт тавьж буй байгууллагын зөвшөөрөлгүйгээр байнга оршин суух газраа солихгүй байх, тодорхой газруудад зорчихгүй байх, тодорхой хугацаанд оршин суугаа газартаа амьдрах, архи, согтууруулах ундаа болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, бэлгийн замын халдварт өвчний цуврал эмчилгээнд хамрагдах, гэр бүлдээ эд хөрөнгийн туслалцаа үзүүлэх зэрэг үүргийг ногдуулдаг байна. Шүүхээс болзолт ял эдэлж буй хүнд засан хүмүүжүүлэхэд

⁶⁸ www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/14

⁶⁹ www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/49

нөлөөлөх өөр бусад үүрэг ногдуулж болно. Түүнчлэн тус улсын Эрүүгийн хуулийн 69.1-р зүйлийн дагуу болзолт ялын хэлбэрээр албадан хөдөлмөр эрхлүүлэх ялтай хамт эрх чөлөөг хасах ял ногдуулж болно.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын Эрүүгийн хуульд⁷⁰ эрх чөлөө хязгаарлах ял нь ялын үндсэн төрөлд багтдаггүй. Харин тус улсын Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн дагуу шүүхээс болзолт ял шийтгэл ногдуулахдаа үндэслэл байна гэж үзсэн тохиолдолд учирсан хор уршгийг тодорхой хугацааны дотор арилгах, ажил эрхлэх юм уу сургуульд хамрагдах, болзолт ял эдэлж буй этгээдийн зан байдалд хяналт тавьж буй байгууллагад оршин суух, ажиллах, сурах газрын өөрчлөлтийг мэдэгдэн тэмдэглүүлэх, эдгээр байгууллагад тогтмол очиж бүртгүүлж байх, тодорхой газруудад зорчихгүй байх, тодорхой хугацаанд оршин суух газартаа байх, архи согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, бэлгийн замын халдварт өвчний цуврал эмчилгээнд хамрагдахыг ялтанд үүрэгдэж болно.

Украин улсын Эрүүгийн хуулийн⁷¹ 61 дүгээр зүйлд заасны дагуу эрх чөлөө хязгаарлах төрлийн ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр албадан хөдөлмөрлүүлэн хяналт тавьж, 1-5 жилийн хугацаанд нээлттэй төрлийн эрүүгийн гүйцэтгэлийн байгууллагуудад байлцуулахад оршино. Тус улсын Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлд заасны дагуу насанд хүрээгүй этгээдэд уг ялыг хэрэглэж болохгүй бол мөн хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу шүүх эрх чөлөөг хязгаарлах болон хасах ялаар шийтгүүлсэн хүнд ялын эдлээгүй хэсгийг илүү хөнгөн ял шийтгэлээр сольж эдлүүлэх боломжтой байдаг.

Бүгд Найрамдах Армен Улсын Эрүүгийн хуульд⁷² эрх чөлөөг хязгаарлах нь ялын төрөлд багтдаггүй. Харин тус улсын Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлд Оросын хууль тогтоомж дахь болзолт ял шийтгэлтэй төстэй зарим зохицуулалт байгаа юм. Тухайлбал шүүхээс ялтанд тодорхой үүрэг ногдуулах боломжтой. Үүнд ялтны зан байдалд хяналт тавьдаг эрх бүхий байгууллагад мэдэгдэлгүйгээр байнга оршин суудаг хаягаа өөрчлөхгүй байх, архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, бэлгийн замын халдварт өвчний эмчилгээнд хамрагдах, гэр бүлдээ эд хөрөнгийн туслалцаа үзүүлэх зэрэг юм. Шүүх ялтны зан байдалд хяналт тавих байгууллагаас тусдаа, ялтныг засан хүмүүжүүлэхэд нэмэр болох өөр үүрэг ногдуулах боломжтой байдаг.

Дээрх улс, орнуудын эрүүгийн хууль тогтоомжуудыг судалсны үндсэн дээр дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

⁷⁰ www.fmc.uz

⁷¹ www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/52

⁷² www.competition.am/uploads/resources/qreakanENG.pdf

Беларусь, Казахстан, Тажикстан, Украин, мөн өмнөх Азербайжаны (2011 онд хасах хүртэлх) эрүүгийн хууль тогтоомжууд дахь эрх чөлөөг хязгаарлахыг ялын үндсэн төрлийн шинжтэй авч үзэж байна. ТУХН-ийн орнуудын хууль тогтоомжуудад эрх чөлөөг хязгаарлахыг ялын нэмэлт төрөл болгон авч үзээгүй байгаа юм. Харин Азербайжан, Армен, Молдав, Туркменистаны эрүүгийн хуулиудад эрх чөлөөг хязгаарлах ялын төрөл байхгүй байна.

ТУХН-ийн орнуудын хууль тогтоомжуудын заримд байх эрх чөлөөг хязгаарлах тухай ойлголт нь ОХУ-ын өмнөх Эрүүгийн хууль (27.12.2009 №377-ФЗ Холбооны хууль батлагдахаас өмнөх) -тай төсөөтэй байгаа байдлыг тэмдэглэх хэрэгтэй билээ. Үүнд зарим нэг онцлогууд байгаа бөгөөд ОХУ-ын хууль тогтоомж дахь болзолт ял шийтгэлийн институттэй мөн төсөөтэй байгаа юм.

Гагцхүү Беларусын хууль тогтоомжид л урьдчилан сэргийлэх хяналтын тусгай арга хэмжээ байна. ТУХН-ийн бусад улсын хууль тогтоомжуудыг судлахад эрхийн хязгаарлалтуудыг эрх чөлөөг хязгаарлах институтийн хүрээнд болон (эсхүл) болзолт ял шийтгэл, болзолтойгоор хугацаанаас өмнө чөлөөлөх хүрээнд авч үзэж байна. Эрх чөлөөг хязгаарлах төрлийн ялыг оршин суугаа газартаа эдлэх явдал гагцхүү Казахстан Улсын Эрүүгийн хуульд авч тусгагдсан байна. Үүнээс гадна Беларусын хууль тогтоомжид оршин суугаа газарт нь эрх чөлөө хязгаарлах ялыг эдлүүлэхгүй байх нь шүүхийн эрх хэмжээнд хамаарч байгаа нь анхаарал татаж байгаа юм. Түүнчлэн оршин суугаа газартаа эрх чөлөө хязгаарлах ялыг эдлэх боломж ТУХН-ийн бүрэлдэхүүнд ордоггүй зарим улсуудад тусгагдсан байгаагаас жишээлбэл, Польшийн ЭХ-ийн 34, 35 дугаар зүйл, Литвын ЭХ-ийн 48 дугаар зүйлд тус тус зааснаар болзолтойгоор хугацаанаас өмнө чөлөөлөхийг зөвшөөрдөггүй. Түүнчлэн Гүржийн Эрүүгийн хуулийн 47-р зүйлийн дагуу эрх чөлөөг хязгаарлах гэж ял ногдуулах үед 18 насанд хүрсэн хүнийг тусгай байгууллагад хяналт бүхий засан хүмүүжүүлэх төвд нийгмээс тусгаарлахгүйгээр байлгахыг ойлгодог.

Судалж буй улс, орнуудын хууль тогтоомжуудад эрх чөлөөг хязгаарлах хугацаа нь ялгаатай байгаа юм. Ингэхдээ эрх чөлөөг хязгаарлах хугацаа нь хэдэн сараас хэдэн жил хүртэл хугацаатай байна. (жишээлбэл, Беларусын ЭХ-ийн 55 дугаар зүйлд 6 сараас, Казахстаны ЭХ-ийн 45 дугаар зүйл, Тажикстаны ЭХ-ийн 54 дүгээр зүйл, Украины ЭХ-ийн 61 дүгээр зүйлд 5 жил хүртэл)

Мөн нэг онцлог зохицуулалт байгаа нь Беларус болон Украины хууль тогтоомжид эрх чөлөө нь хязгаарлагдсан хүнээр албадан хөдөлмөр эрхлүүлдэг.

Мөн судлагдсан ихэнх орнуудын хууль тогтоомжид хөнгөн төрлийн ялыг болон ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд эдлээгүй үлдсэн ялыг эрх чөлөө хязгаарлахаар сольж болдог (үүнд Литва улсад торгууль болон баривчлах ялыг авч үздэг, Украинд эрх чөлөө хязгаарлах ялыг эрх чөлөө хасах ял болон илүү

урт хугацаагаар эрх чөлөө хязгаарлах ялаар солих боломжтой) Эрх чөлөө хязгаарлах ялын эдлэгдээгүй үлдсэн хэсгийг илүү хөнгөн ялаар солих боломжийг Беларусын ЭХ-ийн 91 дүгээр зүйл, Тажикстаны ЭХ-ийн 77 дугаар зүйл, Украины ЭХ-ийн 82 дугаар зүйлд тусгасан байна.

Эрх чөлөөг хязгаарлах төрлийн ял оногдуулж болохгүй хүн нь эрх чөлөө хязгаарлахыг ял хэмээн авч үзсэн ТУХН-ийн улсуудад бүгдэд нь төсөөтэй зохицуулалтуудтай. Үүнд хуульд заасан тодорхой насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэй, хуульд заасан тодорхой насанд хүрээгүй хүүхэдтэй хүн, нэг болон хоёр дугаар зэргийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, цэргийн албан хаагч болон бусад төрлийн (жишээлбэл Казахстаны ЭХ-ийн 45 дугаар зүйлд зааснаар хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүст) хүмүүст оногдуулж болдоггүй. Түүнчлэн байнга оршин суух газаргүй хүнд энэ ялыг оногдуулахыг хориглосон байдаг. Эрх чөлөө хязгаарлах ял эдэлж буй хүнд тавих электрон хяналтыг хэрэгжүүлэх боломжийг дээрх улсуудын хуулиудад бэхжүүлээгүй байгаа нь эрх чөлөө хязгаарлагдсан хүн хязгаарлалтын бүсэд байгаа эсэх болон ялыг эдлүүлэх журмыг мөрдөж байгаа эсэх дээр байнгын тогтмол хяналт тавихад хүндрэл учруулж байгааг дурдах нь зүйтэй. Түүнээс гадна судлан буй дийлэнх улсуудын хууль тогтоомжид тусгагдсан эрх чөлөө хязгаарлах ялыг тусгайлсан байгууллагуудад эдлүүлэхэд тавигдах шаардлага нь уг ялын төрлийг нийгмээс тусгаарлахаар авч үздэг бусад ялтай ойртуулж байна. Эрх чөлөөг хязгаарлах нь бүхэлдээ эрх чөлөө хасах, баривчлах болон нийгмээс тусгаарлахтай холбогдсон бусад ялын төрлөөс нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр гэр бүл, сургуулийн болон ажлын хамт олны дунд хүмүүжих, засрал төлөвшлийг олох боломжоор хангадаг шинж чанараараа ялгаатай байдаг. Гэтэл энэхүү шинж нь тусгайлсан байгууллагад хорих замаар хэрэгжүүлбэл алдагдах юм. Судалгааг бүхэлд нь авч үзэхэд ТУХН-ийн улсуудын тэн хагас нь эрх чөлөөг хязгаарлахыг ялын төрөл хэмээн авч үзсэн байх боловч түүний тус тусдаа элементүүд нь эрүүгийн эрх зүйн бусад (болзолт ял шийтгэл, болзолтойгоор хугацаанаас өмнө суллах) институтийн хамтаар, судалсан бүх улсын хууль тогтоомжид байна. Хэдий тийм ч тэдгээрийн хэрэгжих байдал ОХУ-ын хууль тогтоомжийнхоос доогуур байгаагаас гадна электрон хяналтын төхөөрөмж буюу цахим гав хэрэглэх эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа ялын бодитой хэрэгжих орчин хийгээд, эрх чөлөөг хязгаарлахыг ялын төрлийн хувьд хөгжүүлэх, нийгмээс тусгаарлалгүйгээр орчин үеийн хяналтын аргыг хэрэглэн эдлүүлэх хүрээг тэлж буй нийт Европ болон дэлхийн хандлагаас хоцорч байгаа ажээ.

Балтын орнуудад зорчих эрхийг хязгаарлах ял, цахим гав, электрон хяналтын хөтөлбөрийг хэрэглэж буй байдал /Латви, Эстон, Литва улсуудын жишээн дээр/ дээрх 3 улсын хувьд ижил асуудлууд тулгарч байсан тул энэхүү асуудлыг даван туулах зорилгоор зорчих эрхийн хязгаарлалт, цахим гав, электрон хяналтын төхөөрөмж ашиглах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн

байна. Ингэхдээ нэгдүгээрт шоронд хоригдож буй хоригдлуудын тоог багасгах, хорих ялын сонголтод илүү үр дүнтэй ялын төрлийг бий болгох гэсэн зорилгын дагуу хэрэгжүүлэхээр болсон байна. Ингээд Эстони улс 2007 онд, Литва улс 2012 онд, Латви улс 2015 оноос нэвтрүүлж эхэлжээ.

Эстони улсын хувьд RT буюу радио дохионы төхөөрөмж ашиглаж байгаагаас гадна GPS төхөөрөмж болон согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах төхөөрөмжийг хэрэглэх боломжийг хуульдаа бүрдүүлж өгчээ. Мөн улсын хувьд 3М компанитай 2016 он хүртэл технологи түрээслэх гэрээтэй ажиллаж байгаа ажээ. Хэрэглэх нөхцөлийн хувьд шоронгоос хугацаанаас өмнө тэнсэн суллах, шүүхээс өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээний төрөл болгож, богино хугацаагаар буюу 6 сар хүртэл хугацаанд хорих ялын оронд, хохирогчийг хамгаалах зорилгоор, пробацын хяналтыг хэрэгжүүлэхэд буюу пробацын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус тус хэрэглэдэг байна. Хяналтын төв нь шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дэргэд байрлаж 7 хоногийн 24 цагийн туршид хяналт тавьдаг. Хяналтын нөхцөл нь 3 шатанд /уян хатан, дундаж, хатуу/ хуваагддаг байна. Хяналтын хугацааны хувьд 12 хүртэл сар байдаг.

Литва улсын хувьд RT буюу радио дохионы төхөөрөмжийг хэрэглэн хяналтыг хэрэгжүүлдэг. 5Ci болон SuperCom Limited гэсэн хоёр компанитай 2016 он хүртэл цааш сунгах нөхцөлтэй технологи түрээслэх гэрээний хүрээнд хамтран ажилладаг. Хэрэглэх нөхцөлийн хувьд шоронд хоригдож буй ялтныг хугацаанаас өмнө тэнсэн суллах, өдрийн тодорхой цагт гарах зөвшөөрөл бүхий гэрийн хорионд байлгах ингэхдээ хорих ял эдлэх хугацааг хойшлуулсан тохиолдолд 3 жил хүртэл, эсхүл эрх чөлөө нь хязгаарлах ял шийтгэгдсэн ялтанд 2 жил хүртэл хугацаанд хэрэглэх тус тус нөхцөлтэй байдаг. Гэхдээ тус улсын шүүхийн практикт 2 сар хүртэл хугацаанд хэрэглэж байгаа ажээ. Учир нь 2-3 жил хүртэл хугацаанд цахим гав, электрон хяналтын төхөөрөмж хэрэглэх нь хэт урт хугацаатай гэж үздэг байна. Хяналтын хугацаандаа 1-2 долоо пробацын офицерт очиж бүртгүүлж байх үүрэг авхуулдаг. Мөн пробацын офицер нь гэрт нь болон ажлын байранд нь гэх мэт газруудад очиж биечилсэн хяналтыг хэрэгжүүлдэг. Тус улсын хувьд технологи түрээслэх гэрээтэйгээр ажилладаг боловч өөрсдийн гэсэн төхөөрөмж, программ хангамж зэргийг худалдаж авах чиглэлд анхаарал хандуулж байгаа юм. Тус улсын шүүгчдийн хувьд цахим гав, электрон хяналтын төхөөрөмжийн үр дүнд итгэх итгэл сайнгүй байгааг дурдаж байна.

Латви улсын хувьд Үндэсний пробацын үйлчилгээний газар энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг ба RT буюу радио дохионы төхөөрөмжийг хэрэглэдэг. SuperCom Limited компанитай 2016 он хүртэл технологи түрээслэх гэрээтэйгээр хамтран ажилладаг. Шоронд хоригдож буй ялтныг хугацаанаас өмнө тэнсэн суллах тохиолдолд хяналтын төхөөрөмжийг

хэрэглэн хяналт тавьдаг. Литва улстай нэгэн адил 1-2 долоо хоног тутамд пробацын офицерт очиж бүртгүүлдэг. Хяналтын төхөөрөмж хэрэглэх энэхүү хөтөлбөрийн хугацаа нь 12 сар хүртэл хугацаатай байдаг ажээ.

ОХУ-ын хууль тогтоомжуудад эрх чөлөөг хязгаарлахыг ялын төрөл хэмээн авч үздэг бөгөөд тухайн ялын төрлийн элементийг агуулсан ял шийтгэл, аюулгүйн арга хэмжээнүүд нь бусад улсын хууль тогтоомжуудад (жишээлбэл Болгарын ЭХ-ийн 48 дугаар зүйлд эрх чөлөөг хасалгүйгээр албадан суурьшуулах төрлөөр тусгасан, Туркийн ЭХ-ийн 21, 22 дугаар зүйлд ажлын өрөө, нийгмийн болон нутгийн удирдлагын ажил хийн барагдуулах боломжтой хөнгөн хорих ялыг тусгасан) мөн тусгалаа олсон.

ОХУ-ын хувьд тус улсын Шүүхийн шийдвэрийг 2020 он хүртэл хөгжүүлэх төслийн хүрээнд 2001 оноос эрх хязгаарлах ял хэрэгжүүлэхдээ электрон гавыг мөн хэрэглэх болсон байна. Хэрэгжиж эхлэх үед гадаад орны тоног төхөөрөмжийг хэрэглэж байсан ба 2011 оноос эх орондоо тус тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх болсноор гаднаас худалдан авч байсан зардлаас даруй 4 дахин бага зардлаар үйлдвэрлэх болсон. Улсын хэмжээнд 2013 онд "Электрон мониторинг" хийхэд 109440000 рубль төсөвлөсөн байна⁷³.

ОХУ-ын засгийн газраас 2010.03.31-нд № 198 "Хязгаарлах эрхийн ялын төрөлд ялтанг хянах, аудио болон электрон бусад техник, хангамж хэрэгслийн жагсаалт батлах тухай"⁷⁴ тогтоол гаргаж, практикт нэвтрүүлсэн. Эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэхдээ аудио болон электрон төхөөрөмжүүдийг ашигладаг. Үүнд:

*Зураг 1. Браслет электронный-
Электрон бугуйвч*




*Зураг 2. стационарное
контрольное устройство-
байнгын
хяналтын төхөөрөмж*



⁷³ ФСИН России: Ведомственная целевая программа «Внедрение современных информационно-коммуникационных технологий в деятельность Федеральной службы исполнения наказаний на 2011–2013 годы». М., 2010. С. 66. (хандалт-10.01.2018 он)

⁷⁴ ОХУ-ын хууль тогтоомжийн эмхтгэл 2010. № 14.
http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_99050/ (хандалт-10.01.2018 он)

Зураг 3. мобильное контрольное устройство- хөдөлгөөнт хяналтын төхөөрөмж



Зураг 4. ретранслятор- дахин дамжуулагч: суурин болон хөдөлгөөнт хяналтын төхөөрөмжийн хүлээн авах хүчин чадлын хүрээг нэмэгдүүлэгч.




Зураг 5. персональный трекер - алба хаагчийн трекер: Хиймэл дагуулын ГЛОНАСС/GPS системийн тусламжтай байршил тогтоох алсын зайн дохиолол өгөх электрон гавны нэг төрөл.




Зураг 6. Сервер мониторинга - Мониторинг сервер: бүх мэдээллийг тусгай программ, дэлгэцээр хянах цогц аппарат



Зураг 7. Сервер аудиовизуального контроля - аудио хяналтын сервер: дуу хоолойн мэдээлэл дамжуулах, хадгалах, хүлээн авах хянах цогц аппарат.



Зураг 8. Стационарный пульт мониторинга - байнгын удирдах мониторинг.



Зураг 9. Мобильный пульт мониторинга - Зөврийн удирдах мониторинг.



Улмаар ОХУ-ын хууль зүйн сайдын 2010.10.11-ний өдрийн № 258 тоот тушаалаар “Эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэх журам батлах тухай” эрх зүйн акт баталж, энэ актаараа тус ялыг хэрэгжүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн асуудлуудыг журамлаж өгсөн.

Электрон гавыг хөл болон гарт зүүж хэрэглэх бөгөөд уг гав нь -100-аас +100 градуст тэсвэрлэж, 5 метрийн гүн бүхий давстай болон цэвэр усанд 15 минут хүртэл хугацаанд ажиллах боломжтой. Энэ нь ялтанд усанд орох, хэвийн амьдрах боломжийг олгож байна. Энэхүү төхөөрөмжийг ОХУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дэргэдэх “Мэдээлэл техникийн хангамжийн төв”⁷⁵-д үйлдвэрлэдэг. Гэвч сүүлийн үед энэ байгууллага нь татан буугдах талаар яригдах болсон. Энэ нь тус байгууллагын дарга асан, хурандаа генерал Александр Реймер болон түүний хамтрагчдын буруутай үйлдлээс болж улсад 2,7 сая рублийн хохирол учирсан байна⁷⁶.

Үүнээс үзэхэд, зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхдээ түүнд шаардагдах тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг бусад орны туршлага, ололт амжилт, алдаа дутагдлыг сайтар судалсны дүнд, өөрийн орны онол, практикт нэвтрүүлэх нь юу юунаас илүү чухал болоод байна.

⁷⁵ Федеральное государственное унитарное предприятие "Центр информационно-технического обеспечения и связи Федеральной службы исполнения наказаний <http://www.citosfsin.ru/company/index.php> (хандалт-10.01.2018 он)

⁷⁶ https://ru.wikipedia.org/wiki/Реймер,_Александр_Александрович (хандалт-10.01.2018 он)

2.3. АНУ болон Европын зарим орнуудын зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог

Сүүлийн 20 жилийн хугацаанд цахилгаан хяналтын төхөөрөмж цахим гавын хэрэглээ болон түүнийг ашиглан хяналт тавих хүмүүсийн тоо болон гэрийн хорионд хоригдож байгаа хийгээд зорчих эрхийг хязгаарлах ял, албадлага ногдуулсан хүмүүсийн тоо өссөн байна.⁷⁷ АНУ-д гэхэд насанд хүрсэн болон насанд хүрээгүй хүмүүсийг нийгэмд нь хянах нийт хөтөлбөрийн 20 гаруй хувьд нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж байгаа гэсэн судалгаа байгаа юм. Тухайн улсад зорчих эрхийн хязгаарлалт болон цахилгаан хяналтын төхөөрөмж, цахим гав нь ерөнхийдөө гурван нөхцөлд хэрэглэгдэж байна. Шоронд хоригдохын өмнөх үе, шоронд хорих үе, нөхцөлтэйгөөр суллах үед гэсэн 3 үе байна. Шоронд хоригдохын өмнөх үе шат буюу шүүх хуралдаанаас өмнөх үеийн хяналтад анх удаа гэмт хэрэг үйлдсэн залуучууд хамрагддаг. Шүүхээс шүүх хуралдаанд байлцуулах хүртэл хугацаагаар хяналтад авдаг. Энэ нь манай улсын ЭБШХ-д тусгалаа олсон таслан сэргийлэх арга хэмжээтэй төстэй байдлаар хэрэглэгддэг. Болзолт нөхцөлтэйгөөр суллах үе шатанд засан сайжруулах газраас суллагдаж байгаа этгээдүүдийг хамруулдаг ба зорчих эрхийг хязгаарлаж тэдгээрийг бүрэн суллах хүртэлх хугацаанд цахилгаан хяналтын төхөөрөмж, цахим гавыг хэрэглэн хяналтад байлгадаг.

Зорчих эрхийн хязгаарлалтад байгаа ялтнуудын төрлөөс хамаараад ямар шатны хязгаарлалт, хяналтад байлгах талаарх ажиллагаа нь өөр өөр байдаг. Энэ шатлал нь энгийн хөл хорионы цаг тогтоох болон эрх чөлөө, хөл хөдөлгөөнийг нь бүрэн хязгаарлах гэсэн хоёр шатлалтай.⁷⁸ Эхний шатлал буюу хөл хорио нь тухайн этгээдийг тодорхой цагийн турш гэртээ байхыг шаарддаг. Хоёр дахь шатлал нь тухайн этгээдийг гадагш гарахыг урьдчилан зөвшөөрч тодорхой хугацаанаас бусад хугацаанд бүрэн гэртээ байхыг шаарддаг. Гадагш гарахыг урьдчилан зөвшөөрч тодорхойлсон хугацаанд /09:00-19:00 цагийн хооронд гэх мэт/ ажил хөдөлмөр эрхлэх, сургуульд сурах, эмчилгээ хийлгэх, сүмд очих, өмгөөлөгчтэйгөө уулзаж зөвлөгөө авах, шүүх хуралдаанд оролцох болон бусад шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжуудыг ойлгодог. Хамгийн хүнд зорчих эрхийн хязгаарлалтын хэлбэр нь шүүх хуралдаанд оролцох, эмнэлгийн тусламж авахаас бусад хугацаанд 24 цагийн турш гэртээ хоригдохыг шаарддаг.⁷⁹

⁷⁷ Ralph K., and Robert S. Gable. 2005. "Electronic Monitoring: Positive Intervention Strategies." Federal Probation 69(1). Kansas Department of Corrections. 2014. House Arrest—Juvenile Corrections. Olathe, Kan.: Johnson County Department of Corrections.

⁷⁸ Darren. 2000. "Overview of the Federal Home Confinement Program 1988-1996." Federal Probation 64(2). 11-18.

⁷⁹ Darren. 2000. "Overview of the Federal Home Confinement Program 1988-1996." Federal Probation 64(2): 11-18.

Цахилгаан хяналтын төхөөрөмж ашиглан зорчих эрхийг хязгаарлах хяналтыг хэрэгжүүлэх ялыг хэрэглэхэд тодорхой хэд хэдэн ашигтай талууд бий гэж судлаачид үздэг. Зорчих эрхийн хязгаарлалт болон цахилгаан хяналтын төхөөрөмжийг дэмжигчид уг төхөөрөмж, хөтөлбөрүүд нь санхүүгийн хэмнэлттэй, дахин гэмт хэрэг үйлдэх буюу рецидивизмийг бууруулдаг, хорих ялын сонголтод хэлбэрийг бий болгодог, ялтны байрлаж байгаа газрыг цаг тухай бүрд нь зааж өгч хяналт тавих боломжийг олгодог гэх мэт олон ашиг тусыг дурддаг. Үүнээс хамгийн гол ашиг тус нь шоронд хоригдох хүмүүсийн тоог багасгах нөлөө юм. Тухайн ялтан нь хаана ямар аргаар ял эдлэхээ сонгодог. Мөн шоронгийн барилгын тоог нэмэхгүй байх нь ирээдүйд гарах зардал болон ялтныг шоронд хорихтой холбогдон гарах өдөр тутмын болоод шоронгийн буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиргааны хийгээд үйл ажиллагааны зардлыг багасгадаг. Санхүүгийн хэмнэлтийн ашиг тус нь татвар төлөгч нарын мөнгийг хэмнэж, хорих газрын зардал болон тухайн гэмт этгээдүүдэд захиргааны хяналт тавих зардал гэх мэт зардлуудыг хэмнэхэд тусалдаг. Бодит зардлын хэмнэлтийн хувьд авч үзвэл цахилгаан хяналтын төхөөрөмжийн хөтөлбөр нь өдөрт хаана байгаагаас үл хамааран 5.50 доллароос 10 доллар хүртэлх зардал гаргадаг бол хорих газруудад гаргах өдрийн зардал нь нэг хоригдолд 100 доллароос 160 доллар байдаг. Цахилгаан хяналтын төхөөрөмжтэй, төхөөрөмжгүйгээр зорчих эрх нь хязгаарлагдсан гэмт этгээдүүд нь ажил хийж, өөрсдийн хэрэглэж байгаа хяналтын төхөөрөмжийн түрээс болон ашиглалтын зардлыг төлж байгаа нь мөн төсвийн хөрөнгийн хэмнэлтэд ихээхэн дөхөм үзүүлдэг ажээ.⁸⁰

Одоогоор Америкийн Нэгдсэн Улс нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг үндсэн хорих ялыг хэлбэрээр ашиглаж байгаа ба энэ нь шоронд хорихоос илүү их хүлээцтэй байдлыг шаарддаг хэдий ч тэнсэн суллахаас илүү хязгаарлалтад байдаг. Эрх зүйн статистикийн хэлтсээс гаргасан судалгаанд 1998 оны үед Америкийн Нэгдсэн Улсад нийт 19677 хүмүүсийг цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглан тэнсэн сулласан байна. Америкийн Нэгдсэн Улсын хойд бүс нутгаар цахилгаан хяналтын төхөөрөмжийг хорих ялын шууд нэгэн сонголтод хэлбэр гэж үздэг. Эхлээд шүүхээс тухайн этгээдийг шоронд хорихоор хорих ялаар шийтгэдэг ба хэрэв гэмт этгээд нь засан сайжирсан, зан үйлийн хувьд зохистой хэмжээнд хүрсэн гэж үзвэл хорих ялын үлдсэн хугацааг гэрийн хорионд эдлэхийг хүлээн зөвшөөрдөг.

Нью Сауд Вэйлсд үүнтэй адилаар цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад дор гэрийн хорионд ял эдлэхийг зөвшөөрдөг. Хэдий ингэж хүлээн

⁸⁰ Sklaver, Stacey L. 2010. "The Pros and Cons of Using Electronic Monitoring Programs in Juvenile Cases." Juvenile Justice Committee Newsletter, No.5. Washington, D.C.: American Bar Association.

зөвшөөрдөг ч гэсэн ялтанд уг сонголт хийх эрх нь хорих ялыг шоронд биечлэн эдэлж эхэлсний дараа нээгддэг.

Америкийн Нэгдсэн Улсад цахилгаан хяналтын төхөөрөмжийг шүүх хуралдаанаас өмнөх процесст хэрэглэж байна. Уг ажиллагаа нь батлан даалтын мөнгө төлөх боломжгүй сэжигтэн, яллагдагчдад зориулсан байдаг. Мөн хэрэг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор шүүх хуралдаан болоогүй болон гэмт хэрэг үйлдсэн эсэх нь тодорхойгүй нөхцөлд цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэдэггүй.

ИБУИНВУ-ын бүрэлдэхүүнд багтах Шотландын тухайд 2002 оноос эхлэн зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэж эхэлжээ. Ингэхдээ шүүхээс шоронд хорих ялын сонголтод хэлбэрээр оногдуулах боломжтойгоор хэрэглэж эхэлсэн байна. Шотландад цахим гав, цахилгаан хяналтын төхөөрөмжийн үйлчилгээ, хэрэглээг Засгийн газар болоод хувийн компани хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр явагддаг.⁸¹ 2013 оны 4 сард Шотландын засгийн газраас Серко /Serco/ компанитай байгуулсан гэрээ дуусгавар болж G4S компанитай гэрээлж дараагийн 5 жилд хамтран ажиллахаар болсон байна. Дэлхийн жишгийн дагуу Шотландад цахим гав, цахилгаан хяналтын төхөөрөмжийн хэрэглээ нь шүүхээс өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ байдлаар хэрэглэгдэх, шүүхээс ял шийтгэл хэлбэрээр оногдуулах болоод ялтан суллагдсаны дараа түүнд тавих хяналтын хэлбэрээр хэрэглэгддэг. Шотландад байршил дамжуулах болон мэдээлэл дамжуулах төхөөрөмжийн тусламжтайгаар тавих хяналт нь дараах төрөлтэй байдаг. Үүнд:

- Эрх чөлөө хасагдсан хүнд тавих хяналт /RLO/
- Зорчих эрх хасагдсан хүнд тавих хяналт /CPO/
- Нөхцөлтэйгөөр сулласан ялтанд тавих хяналт /гэрийн хорионд оруулах эсхүл хяналтын бүсээс гарахгүй байх, тодорхой маршрутаар зорчих нөхцөл тулгах/
- Мансууруулах бодис хэрэглэсэн эсэхэд тавих хяналт /DTTO/ гэх мэт.

Шотландын 2003 оны Эрүүгийн шүүн таслах ажиллагааны актын 40-р зүйлийн дагуу зорчих эрхийг хязгаарлах буюу эрхийн хязгаарлалтын ял, цахим гав, цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэх талаарх шийдвэрийг шүүх гаргадаг.

Бусад эрх зүйн тогтолцоотой улс орнуудад шүүгч нь ерөнхий эрх мэдлийнхээ хүрээнд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж байна. Тухайлбал, Тасманийн Хорих ял эдлүүлэх тухай 1997 оны актад шоронд хорих ялыг бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоож ялтан засан сайжирсан, тохиромжтой

⁸¹ Development of Electronic Monitoring in Scotland A Consultation on the Future Direction of the Electronic Monitoring Service. September 2013. www.scotland.gov.uk. p 2.

гэж шүүхээс үзвэл цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад гэрийн хорионд байхыг зөвшөөрдөг.⁸²

Шүүх хуралдаанаас өмнөх үе шатанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг хариуцагчийг батлан даалтад суллах тохиолдолд хэрэглэгддэг. Батлан даалтад гаргах болзол нь шүүх хуралдаанд хариуцагчийг оролцуулах болон дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх гэсэн нөхцөлүүд байдаг ба өөр нэмэлт шахалт, дарамт бүхий үүргийг оногдуулдаггүй. Энэ үе шатны хувьд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ял шийтгэлийн хэлбэрээр ашигладаггүй. Иймд тухайн сэжигтэн, яллагдагчийг заавал хязгаарлах, хорих шаардлага байхгүй бол цахилгаан хяналтын төхөөрөмжийг хяналт тавих зорилгоор ашигладаг.

Батлан даалтын үед дэх цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглах ажиллагаа нь Их Британид 1989 оноос эхэлсэн бөгөөд нийт 50 гаруй сэжигтэн, яллагдагчид уг төхөөрөмжөөр хяналт тавьж байжээ. Уг процесс ажиллагаа нь одоог хүртэл Их Британид ашиглагдаж байна. Жишээлбэл, цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглан хяналт тавих зорилгоор 12-оос 16 настай хариуцагч нарыг суллах ажиллагаа хийгддэг.

Канад Улсад цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтыг ашиглан батлан даалтад суллах эсэх асуудлыг зохицуулсан тусгайлсан хууль тогтоомж байхгүй хэдий ч шүүхээс өөрийн ерөнхий бүрэн эрхийнхээ хүрээнд зарим хариуцагч нарыг гэрийн хорионд байлгаж, цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглахыг зөвшөөрдөг.

Шүүх хуралдаанаас өмнөх үе шатанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж болох хоёр тохиолдолд байдаг. Нэгдэх нь гэр оронгүй этгээдүүдэд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигладаг. Өнөөгийн байдлаар ихэнх гэр оронгүй хүмүүс нь хорих газар байрлаж байна.

Өмнөд, хойд Австралийн эрх зүйн тогтолцоонд үндсэн ял буюу хорих ялыг цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад дор гэрийн хорионд эдлэхийг зөвшөөрсөн тусгайлсан хууль тогтоомж байдаг. Хойд Австралийн Ял эдлүүлэх тухай 1995 оны актад ялтанг ял эдлэх хугацаанд нь гянданд хорих ажиллагааг зогсоогоод гэрт нь үргэлжлүүлэн үлдсэн ялыг нь эдлүүлж болохыг заасан байдаг. Гэрийн хорионд байгаа ялтанг цахилгаан хяналтын төхөөрөмжийг зүүхийг шаарддаг.

Австралийн Хүний Эрхийн Зөвлөл нь хорих газар байлгахаас гадна уг хүмүүст цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналт дор байх сонголтыг өгөх ёстой хэмээн зөвлөж байна. Хоёрдох хэрэглээ нь хохирогч, гомдол гаргагчаас гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг тусгаарлах, тэдгээрийг урьдчилан

⁸² Matt Black and Russell G. Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology. Canberra. 2003. p 3.

хамгаалахын тулд хөл хорио тогтоох, хязгаарлалтын хэлбэрээр ашиглаж байна. Цахилгаан хяналтын төхөөрөмжийн дээрх хоёр хэрэглээний аль аль нь Австрали улсад байдаггүй ч гэсэн орчин үеийн хязгаарлалт болон хяналт тавих шаардлагатай үед уг төхөөрөмжийг ашиглахыг улам ихээр шаардаж байна.⁸³ Зөвхөн Баруун Австралид шүүх хуралдаанаас өмнө цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж болох талаар зохицуулалт байдаг. 1982 оны Батлан даалтын актад шүүхийн шийдвэр гүйцэтгэгч офицерын хяналтын дор 17 наснаас дээш насны сэжигтэн, яллагдагчийг гэрийн хорионд хорихыг хүлээн зөвшөөрдөг. Гэрийн хорионд батлан даалтад суллагдахын тулд дараах материалуудыг бүрдүүлдэг. Нэгдүгээрт Хорих газрын офицероос зөвшөөрөл авна, дараа нь сэжиглэгдэж байгаа этгээд цахилгаан хяналтын төхөөрөмжийг биедээ суурилуулах, эсхүл байрлах газар нь суулгахыг зөвшөөрсөн байх ёстой.

Ихэнх эрх зүйн тогтолцоонд цахилгаан хяналтын төхөөрөмж нь батлан даалтад суллах үед ихэвчлэн хэрэглэгдэж байна. Жишээлбэл, Өмнөд Австралийн 1985 оны батлан даалтын тухай актад батлан даалтад гаргаж байгаа эрх бүхий этгээд нь тухайн хүнийг оршин байрлах газарт нь хараа хяналтдаа байлгаж болохыг зөвшөөрсөн байдаг. Уг зүйл заалтад цахилгаан хяналтын төхөөрөмжийн талаар тодорхойлон заагаагүй байдаг хэдий ч Өмнөд Австралийн Дээд шүүхээс уг заалтыг тайлбарлахдаа эрх бүхий офицер нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж болохоор тайлбарласан.⁸⁴

Ялтанг ял эдлэх хугацаанаас нь өмнө нийгэмд суллаж байгаа тохиолдолд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигладаг. Жишээлбэл, Их Британи Улсад хорих ялын хугацаа дуусах дөхөхөөр шоронгоос нийгэмд буцаан шилжүүлэх тохиолдолд цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэдэг.

Мөн Шинэ Зеланд Улсад цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад дор ялтныг хорих ялын хугацаа дуусахаас өмнө гаргадаг тохиолдол нь 1999 оноос эхэлсэн. Технологийн жижиг асуудлууд болон ялтны гэр бүл, хань ижлээс цахилгаан хяналтын төхөөрөмжид үзүүлэх сөрөг хандлагууд байсан хэдий ч уг ажиллагаа маш амжилттай явагдсан байна.

Өмнөд Австралид хорих ял эдлэх сүүлийн 6 сарын хугацаанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглахыг зөвшөөрдөг. Ялтан нь цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналт дор нийгэмд суллагддаг бөгөөд уламжлалт батлан даалтад тэнсэн суллах ажиллагаа болон хорих ялыг дуусгах аль аль ажиллагаанд нь уг ажиллагаа байдаг байна. Кьюнсландад үүнтэй адилхан программ байдаг ба хорих ялын хугацаа дуусахад ялтныг цахилгаан хяналтын

⁸³ Matt Black and Russell G. Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology. Canberra. 2003. p 3.

⁸⁴ Matt Black and Russell G. Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology. Canberra. 2003. p 3.

төхөөрөмжийн хяналтад гэрийн хорионд хийдэг. Ялтнууд нь хорих ялын хугацаа дуусахаас өмнө уг программд 3-аас 4-н сарын турш байдаг.⁸⁵

Хойд, Өмнөд Австралид ял эдэлсний дараа захиргааны хяналтад ялтныг авахын тулд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигладаг. Баруун Австралийн 1995 оны Захиргааны хяналтын тухай актад зааснаар тодорхой ялтнуудыг гэрийн хорионд суллахыг зөвшөөрдөг. Тэдгээр ялтнуудыг цахилгаан хяналтын төхөөрөмжийг байрлаж амьдрах газартаа болон биедээ суулгах, суурилуулахыг зөвшөөрсөн байхыг шаарддаг. Мөн Кьюнсландын 2000 оны Засан сайжруулах арга хэмжээний тухай актад ялтанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг суулгаад нийгэмд суллах талаарх зохицуулалтыг заасан байдаг.

Нью Сауд Вэйлсийн 1999 оны Гэмт хэргийн тухай актад зааснаар тэнсэн суллах арга хэмжээ авч цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад гэрийн хорионд суллахыг зөвшөөрдөг. Мөн Ялтныг нийгэмжүүлэх тухай 2001 оны актад зааснаар Австралийн төв зөвлөлд мөн цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглах бүрэн эрхийг олгосон байдаг.⁸⁶

Баруун Австралийн Хорих ялын тухай 1995 оны актад шүүх ялтныг ял эдлэх хугацаанд нь онцгой, эрчимтэй хараа хяналтад байлгуулах тухай шийдвэрийг гаргаж болно гэж заасан. Уг шийдвэрийг гаргахын тулд ялтан нь шүүхийн шийдвэрт заасан хараа хяналтад байх ба түүний гэрт эсхүл биед нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг суурилуулдаг. Цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад байх хугацааг шүүхээс 6 сар ба түүнээс доош хугацаагаар оногдуулж болдог.

Нью Сауд Вэйлсийн хууль тогтоомжид цахилгаан хяналтын төхөөрөмжийн талаар тусгайлсан заалт байхгүй хэдий ч Гэмт хэргийн тухай 1999 оны актад шүүгч шаардлагатай, зохистой гэж үзсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэрийн хорионд ял эдлүүлэхээр шийдвэр гаргаж болно гэж заасан. Практикт цахилгаан хяналтын төхөөрөмжийг гэрийн хорионд байх хугацаанд хэрэглэж байна.

⁸⁵ Matt Black and Russell G.Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology.Canberra. 2003. p 3.

⁸⁶ Matt Black and Russell G.Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology.Canberra. 2003. p 3.

2.4. Бүгд Найрамдах Солонгос улсын зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог

Зураг 10. Олон улсын жишиг



Зураг 11. Цахим хяналтын системийг нэвтрүүлэх явц





2006. 2. Бага насны Хүүхдийг хүчиндэж амь насыг нь Хороосон хэрэг

•2007. 4. Хууль гарсан

2008. 3. Бага насны Хүүхдийг барьцаалсан хэрэг

•2008. 6. Нэмэлт өөрчлөлт

2008.12. Жодусоны хэрэг

•2008.9. Хэрэгжиж эхэлсэн

Хүүхэд хулгайлах гэмт хэргийг оруулсан

•2009.5. 2 дахь нэмэлт өөрчлөлт

2010. 2. Кимгил тэ-н хэрэг

•2010.4. 3 дахь нэмэлт өөрчлөлт

Тусгайлсан гэмт хэрэгтнийг хянан харгалзах, цахим төхөөрөмж ашиглах тухай хууль

Энэхүү хууль нь 6 бүлэг, 38 зүйлтэй.

I бүлэгт: Ерөнхий зүйл, зорилго, нэр томьёо, хариуцлага зэргийг хуульчилсан.

II бүлэгт: Ял эдлүүлэх ажиллагааны дараах хяналт.

III бүлэгт: Хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд тавих хяналт.

IV бүлэгт: Тусгайлсан гэмт хэрэгт тавих цахим хяналт.

V бүлэгт: Төхөөрөмж ашиглалт.

VI бүлэгт: Зөрчсөн этгээдэд хүлээлгэх шийтгэл, хариуцлагын харилцааг тус тус зохицуулсан.

Хуулийн зорилго:

Тусгайлсан гэмт хэргийг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс ял, шийтгэл эдэлсний дараа хянан харгалзах, хууль сахиулах албан хаагчаар дамжуулан хяналт тогтоож, удирдан чиглүүлснээр эрүүл нийгэмд эргэн дасан зохицох явцыг хурдасгах, байршил тогтоох төхөөрөмжийг биед нь зүүлгэх (суулгах) нэмэлт арга хэмжээг

авснаар тусгайлсан гэмт хэрэгтнээс иргэдийг хамгаалах харилцааг зохицуулахад оршино.

"Тусгайлсан гэмт хэрэг" гэдэг нь хүчин, насанд хүрээгүй хүүхдийг уруу татах (гэмт хэрэгт татан оруулах, өөрийн хүсэл зорилгоо ёс бусаар гүйцэлдүүлэхэд ашиглах) гэмт хэрэг, хүний амь насны эсрэг гэмт хэрэг, дээрмийн гэмт хэргийг хэлнэ.

"Байршил тогтоох төхөөрөмж" гэж цахим долгионыг цацах үндсэн зарчимд тулгуурлан байршил тодорхойлж, шилжилт хөдөлгөөнийг илрүүлэх нэгэн төрлийн төхөөрөмж.

19 нас хүрээгүй этгээдэд энэхүү төхөөрөмжийг суулгах шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэж эхлэх хугацааг уг этгээдийг 19 нас хүртэлх хугацаагаар тэнсэн харгалзаж хойшлуулна.

ПРОКУРОР: Тусгайлсан гэмт хэргүүдэд цахим хяналт тогтоох саналаа шүүхэд гаргана.

ШҮҮХ: 19 нас хүрээгүй этгээдийн хувьд төхөөрөмж зүүлгэх үндсэн хугацааны хамгийн доод хугацааг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээнд тогтооно.

- Цаазын болон бүх насаараа хоригдох ял : 10-30 жил хүртэл;
- Биеэр эдлэх 3 жилээс дээш хорих ялаар шийтгэгдэх тусгайлсан гэмт хэрэг 3 жилээс дээш 20 жил хүртэл;
- Биеэр эдлэх 3 жил хүртэлх ял шийтгэлд хамаарах тусгайлсан гэмт хэрэг 1 жилээс дээш 10 жил хүртэл;
- Олон төрлийн тусгайлсан гэмт хэрэгт нэгэн зэрэг шийтгүүлсэн тохиолдолд хамгийн хүнд гэмт хэрэгт ногдуулах төхөөрөмж суурилуулах хугацааны 2/1 хүртэлх хугацаагаар нэмэгдүүлэх бөгөөд нийт гэмт хэрэгт ногдуулах төхөөрөмж зүүх дээд хугацааны нийлбэрээс хэтрэхгүй байна.

Шүүх дараах тохиолдолд шийдвэр гарган төхөөрөмж зүүлгэх саналаас татгалзана:


1. Тусгайлсан гэмт хэргийн хувьд гэм буруугүй нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд;

2. Тусгайлсан гэмт хэрэгт торгох, тэнсэн харгалзах шийтгэл авсан тохиолдолд;

Хянан харгалзагч нь мөнгө, бэлэг сэлт, амлалт авч төхөөрөмжийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр салгасан, гэмтээсэн бол хэргийг үйлдсэн тохиолдолд 2-с дээш жилийн хорих ялаар шийтгэнэ.

Хяналтад байгаа этгээд төхөөрөмжийг санаатай салгаж, мэдээллийг доголдуулсан эсвэл хууль бус аргаар мэдээллийг өөрчилсөн бол 7 жил хүртэлх

хугацаагаар хорих эсвэл 20 сая вон хүртэлх хэмжээгээр торгох шийтгэл онооно.



Цахим хяналтын тогтолцоо

- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн биед байршил тогтоох цахим (гав) хяналтын төхөөрөмж зүүн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх ажиллагаа

24 цагийн турш байршлыг тодорхойлж хянан харгалзагчийн удирдлага, хяналтад орсноор дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх.

Хэлбэр

- Гэрийн хорио/ Байршил тогтоох буюу зорчих хэсгийг хянах


Гэрийн хорио

Хорих ангийн нягтаршлыг багасгах, төсвийн ачааллыг бууруулах, богино хугацаа бүхий хорих (баривчлах) шийтгэлээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах

Байршил тогтоох (зорчих хэсгийг хязгаарлах)

Нийгэмших явцад хяналт тавих, зорчих эрхийг хязгаарлах бөгөөд ял шийтгэлийг хөнгөрүүлсэн арга хэрэгсэл

Зураг 12. Доорх гэмт хэргийг үйлдсэн этгээдийн зорчих хэсгийг хязгаарлана



Зураг 13. Цахим гавыг хэрэглэж эхлэх



Зураг 14. Цахим хяналтыг хэрэгжүүлэх дараалал



Зураг 15. Ял эдлэх субъектийн үүрэг



Зураг 16. Үүрэг (Тусгай)




Цахим хяналтын хугацаа

- Үндсэн ялын хугацаа дууссан этгээдэд: 1 ~ 30 жил хүртэлх хугацаагаар;
 - 19 нас хүрээгүй этгээд энэ хуульд хамаарагдах гэмт хэрэг үйлдсэн бол ял эдэлснээс хойш 2 жил хүртэлх хугацаагаар;
 - Буцаан хэрэглэх тохиолдолд суллагдсанаас хойш: 10 жил хүртэлх хугацаагаар;
 - Өвчин болон түүнтэй адилтгах шалтгааны улмаас хугацаанаас өмнө суллагдсан бол: 3 жил хүртэл.
 - Магадлангаар буюу хөнгөлөлттэй нөхцөлөөр суллагдсан бол үлдсэн хугацааг оруулаад 10 хүртэлх жил;
 - Ял хойшлуулах болон тэнсэн харгалзсан бол: 5 хүртэлх жил.

Зураг 17. Цахим гавын хөгжил

Анхны загвар	2-р	3-р	4-р
			
0.49%	0.85%	1.40%	0.23% 1.34%
<ul style="list-style-type: none"> • Зөөлхөн, нимгэн • Биед эвтэйхэн 	<ul style="list-style-type: none"> • Холбоосыг сайжруулсан 	<ul style="list-style-type: none"> • Уян ган хийцтэй • Зүүхэд биед мэдрэмтгий/ төвөгтэй. 	<ul style="list-style-type: none"> • Цэнэглэдэг зай • Зэвэрдэггүй ган хийцтэй

Зураг 18. GPS Байршил тогтоох систем



Зураг 19. Төхөөрөмжийн танилцуулга


Гав	Орон байрны /суурин/	Байршил тогтоогч
		
Зөөврийн цэнэглэгч	Гэрийн	Машины

		
Уут	Цэнэглэгч адаптер	Цэнэглэгч суурь
		 Зонгио кервтер

Зураг 20. Системийн холбоос



Зураг 21. Байршил тогтоох чанарыг нэмэгдүүлэх /байрлалын цэгийг илүү нарийвчлалтай болгох



Зураг 22 Улсын хэмжээнд төхөөрөмжийг зүүсэн этгээдийн тоо

Одоогийн байдал		Хүлээгдэж буй (Ял, шийтгэлээ дуусгаад суллагдсаны дараа хэрэгжүүлэх)		
2,707		2,486		

Одоогоор хянан харгалзаж буй этгээдүүийн гэмт хэргийн төрөл				
Нийт	Хүчин	Хүүхэд хулгайлах	Хүн амь	Дээрэм
2,707	2,203 (81%)	7 (0.3%)	381 (14%)	116 (4%)

Үр дүн

Зураг 23. Хүчингийн гэмт хэрэг гаралтын хувь



Зураг 24. Хянан харгалзагч болон цагдаагийн байгууллага хоорондын эрх зүйн туслалцаа үзүүлэх хамтын ажиллагаа



ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

3.1. Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулж буй байдал

Хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрүүгийн хуулинд нийт 1088 үйлдлийг гэмт хэрэгт тооцож “Хорих, торгох, эрх чөлөө хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх болон эрх хасах” ялын төрлийг үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулах тухай заасан байна⁸⁷

Зураг 25. Шинэчлэн батлагдсан “Эрүүгийн хууль”-д тусгасан ялын төрлүүдийн тус бүрийн эзлэх хувь:



Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 төрлийн буюу бөгөөд хөнгөн 121, хүнд 119 гэмт хэрэг тус тус ногдуулахаар тогтоожээ. Мөн зорчих эрхийг хязгаарлах эсхүл хорих ялын аль нэгийг сонгож хэрэглэхээр хүнд гэмт хэргийн 119, хөнгөн гэмт хэргийн 57 заалтад буюу “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг” “Авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг”-т түлхүү ногдуулахаар хуульчилсан байна.⁸⁸

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167-176 дугаар зүйлд энэ төрлийн ялын хэрэгжилтийг хэрхэн хангах талаар дараах байдлаар зохицуулсан ба үүнд: - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1 дэх хэсэгт “Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа хаяг болон хөдөлмөр эрхэлж байгаа,

⁸⁷ Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Монгол Улсын Эрүүгийн хуулин дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Сүлд-Инфо сэтгүүл” УБ., 2021.53 дахь тал

⁸⁸ Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он

эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.

- 167 дугаар зүйлийн 167.2 дахь хэсэгт "Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.

- 167 дугаар зүйлийн 167.3 дахь хэсэгт "Шийдвэр гүйцэтгэгч, ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар болон ял эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

- 168 дугаар зүйлийн 168.1 дэх хэсэгт "Зорчих эрхийг хязгаарлах ял" шийтгүүлсэн ялтны хүлээх үүрэг.

- 170 дугаар зүйлийн "Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх журмыг зөрчих, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих"

- 170.1 дэх хэсэгт "Дараах тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журам"-ыг зөрчсөнд тооцно. Үүнд:

- Энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй.

- Техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагаа сарниулсан.

- Техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаанд санаатайгаар зайлхийсэн.

170 дугаар зүйлийн 170.2 дахь хэсэгт "Дараах тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журам"-ыг ноцтой зөрчсөнд тооцно. Үүнд:

- Энэ хуулийн 168.1-д заасан үүргээ 3 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа биелүүлээгүй.

- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн.

- Энэ хуулийн 170.1.2, 170.1.4-т заасан зөрчлийг давтан гаргасан.

- Шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн.

- Техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлхийсэн.

- Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино гэж тус тус заажээ.

Түүнчлэн эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт "Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ял ногдуулсан тохиолдолд ялтны нийт эдлэх ялын хугацааг хоёр дахин багасгаж, эдлүүлэхээр"

Гэмт хэрэг үйлдсэн нь баримтаар нотлогдсон этгээд учруулсан хохирлоо нөхөн төлж, засарч хүмүүжсэнээ баталж гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол шүүх зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр.

Ялтан ял эдлүүлэх нөхцөл журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд нэг сард 5 хүртэлх шагналын хоног олгохоор тус тус зохицуулсан байна.


“Эрүүгийн хууль”-д зорчих эрхийг хязгаарлах ялыг шинээр нэмж улмаар 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжилтийг хангахаар зохицуулсан бөгөөд тус ялын биелэлтийг хангах, бэлтгэл ажлыг хангуулах, техникийн цахим хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны бүтцэд “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг байгуулсан.

Цахим хяналт, удирдлагын төв нь улсын хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд техникийн цахим хяналтыг тасралтгүй тавих, ялтны зүгээс гаргасан анхааруулга, зөрчлийн мэдээллийг харьяа газар, хэлтэс, байгууллагын холбогдох албан тушаалтанд шуурхай дамжуулах, ялын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангуулах, удирдлагыг нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах, хяналтын тоног төхөөрөмжийг засварлах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.⁸⁹

Монгол Улсын хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ялыг шүүхээс ногдуулж эхэлсэн үеэс 2021 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж хяналтад орсон 983, аймаг, нийслэл, сум дундын анхан шатны шүүхийн захирамжаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлж хяналтад орсон 77, нийт 1210 ялтан Цахим хяналт, удирдлагын төвийн Зорчих эрхийг хязгаарлах хяналтын системд бүртгэгдсэн ба үүнээс ялын хугацаа дуусч суллагдсан 74, зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааг хорих ялаар дүйцүүлж сольсон 27 ялтан тус тус байна.

Зураг 26. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /2021.11.30-ний өглөөний 09.00 цагийн байдлаар 1210 ялтан/

⁸⁹ Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал”. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 181 дэх тал




Зураг 27. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Нийслэлийн хэмжээнд/




Зураг 28. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Орон нутгийн хэмжээнд/




Зураг 29. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Насны ангиллаар/



Зураг 30. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Хүйсийн байдлаар/




Зураг 31. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны судалгаа /Ял эдлэх хугацаа/



Зураг 32. 2021- 2025 он хүртэл ял эдэлж хугацаа дуусах ялтны судалгаа




Зураг 33. Давтан гэмт хэрэг үйлдсэн байдлаар




Зураг 34. Гэмт хэргийн өнгө



Зураг 35. Зөрчлийн төрөл



Зураг 36. Хяналтаас гарсан ялтны мэдээлэл



3.2. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд хийсэн шинжилгээ

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй цахим бугуйвч нь "хориглосон бүсэд нэвтрэх", "хязгаарласан бүсээс гарах", "бүсийн хязгаарт ойртсон", "явах маршрутаас гарсан" тохиолдолд цахим бугуйвчид анхааруулах мессеж илгээх болон "Цахим хяналт, удирдлагын төв"-ийн "хяналтын нэгдсэн систем"-д 24 цагийн турш тасралтгүй "анхааруулга, дохио" дамжуулах горимоор ажилладаг.

Цахим бугуйвч нь хүний биед харшил өгөхгүй, хүний гар болон хөлд зүүхээр тохируулсан, хөнгөн жинтэй, ус, доргио, шорооны хамгаалалттай, халуун хүйтэнд тэсвэрлэх боломжтой, таслах, тайлах, оролдох үед хяналтын нэгдсэн системд анхааруулга өгөх горимоор ажилладаг бөгөөд зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд нийт 9 төрлийн анхааруулга дохио ирдэг. Үүнд:

- Цэнэг дуусаж байна 30%.
- Цэнэг дуусаж байна 5%, Яаралтай цэнэглэнэ үү.
- Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан.
- Яаралтай үеийн дуудлага. (SOS)
- Маршрутаас гарсан.
- Хориглосон бүсэд 200 метр ойртсон.
- Хориглосон бүсэд нэвтэрсэн
- Бугуйвч оосор тайлагдсан.
- Бүсийн хязгаарт 200 метр ойртсон.

2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс "Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем"-д цахим хяналт хийж ажиллахад нийт 1643 анхааруулга, дохио ирсэн бөгөөд "Цахим хяналт, удирдлагын төв"-ийн алба хаагчид хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарт тухай бүр мэдэгдэж, илэрсэн зөрчлийг арилгаж, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Зорчих эрхийг хязгаарлах хяналтын системд ялтан бүртгэж, хяналтад авсан цагаас хойш ирсэн нийт анхааруулга дохионы 70.7% хувийг "цэнэг дуусаж байна 30%" гэсэн анхааруулга, дохио эзэлж байгаа нь ялтанд зүүлгэсэн цахим бугуйвч нь зай цэнэгээ хангалтгүй барьж байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй цахим бугуйвчаар хяналт тавихад дараах хүндрэлтэй асуудлууд байна. Үүнд:

- Цахим бугуйвчийн цэнэг дууссан тохиолдолд дахин цэнэглэхэд төвөгтэй бөгөөд суурин цахилгааны эх үүсвэрээр зориулалтын цэнэглэгчээр

бүрэн цэнэглэсэн үедээ цэнэгээ барих хугацаа хагас өдөр буюу 10-12 цагаас хэтрэхгүй.

- Зориулалтын цэнэглэгчээр суурин цахилгаан эх үүсвэрт холбож бүрэн цэнэглэхэд дунджаар 01.30 цагийн хугацаа зарцуулдаг бөгөөд цэнэглэх хугацаанд ялтан нэг цэгт хөдөлгөөнгүй байрлах шаардлагатай бөгөөд цэнэглэгч богино тул цэнэглэхэд хүндрэлтэй. /цэнэглэгч 40 см урттай/

- Зөөврийн цэнэглэгчээр цахим бугуйвчийг зөвхөн 1 удаа бүрэн цэнэглэх боломжтой ба бүрэн цэнэглэхэд 30-40 минут зарцуулж 4-5 цагийн хугацаанд цэнэгээ барьдаг.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд хяналт тавьж буй 34 шийдвэр гүйцэтгэгчээс хүндрэлтэй асуудлын талаар судалгаа авахад 21 буюу 61.7% нь цэнэг хурдан дуусдаг гэх хариулт өгч байгаа нь цахим бугуйвчийн чанарын асуудлыг дахин авч үзэх шаардлагыг хөндөж байна.


Сүлжээтэй холбоотой тулгамдаж буй асуудал Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг зөвхөн үүрэн холбооны сүлжээ орсон газарт хангуулах боломжтой тул засаг захиргааны нэгжүүдэд түгээмэл тархсан үүрэн холбооны оператор болон 2G сүлжээ дэмждэг цахим бугуйвчийг сонгон ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж эхэлсэн.

Ялтанд тавих техникийн хяналтыг үүрэн холбооны сүлжээний /сим карт, 2G data/ буюу түүний мэдээлэл дамжуулагч /GPS/-ийн тусламжтайгаар ялтны байршил, хөдөлгөөнийг тогтоож, тухайн мэдээллийг цахим хяналтын системд мэдээлэх байдлаар хяналтыг хэрэгжүүлдэг.

Ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй цахим бугуйвч нь БНХАУ-д үйлдвэрлэсэн бөгөөд 2G сүлжээний "data" буюу интернетийн хурдаар мэдээлэл дамжуулан хяналтыг цахимаар тавих боломжтой байдлаар зохицуулагдсан.

2G сүлжээ нь тархцын хувьд манай орны нутаг дэвсгэрийг өргөн хамрах хэдий ч мэдээлэл, дохио дамжуулах хурд нь "384 kbps" буюу 3G сүлжээнээс 112 дахин бага хурд, хүчин чадалтайгаас гадна үүрэн холбооны ачааллаас шалтгаалан сүлжээ унах, тодорхойгүй хугацаагаар тасрах, мэдээлэл дамжуулагч нь цемент, төмөр, бетон, тоосгоор баригдсан барилга, байгууламж болон байгалийн төрөл бүрийн тогтоц /өндөр уул, даваа, нугачаа/-д ойж, сарнин алдах тохиолдол түгээмэл байдаг.

Зураг 38. Үүрэн холбооны технологийн хөгжлийн зураг.



Хүний нөөцийн хувьд тулгамдаж буй асуудал Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/217, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын ачааллын жишиг, норматив”-д “Нийслэлд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид 160 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулна” гэж заасан.


2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 4154 хоригдол хоригдож байснаас “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, ял дүйцүүлэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн 983 ялтан суллагдаж цахим хяналтад шилжсэн нь “Цахим удирдлага, хяналтын төв” болон Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачааллыг даруй 80-90 хувиар нэмэгдүүлсэн буюу Нийслэлд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 1 шийдвэр гүйцэтгэгчид дунджаар 417 гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулж байна.

Зохион байгуулалтын хувьд тулгамдаж буй асуудал Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжих хугацаанд ноцтой зөрчил гаргаж оргон зайлсан 28 ялтныг эрэн сурвалжлах ажиллагааг тухайн ялтанд хяналт тавин ажиллаж буй харьяа аймаг, нийслэлийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны шийдвэр гүйцэтгэгч нар биечлэн зохион байгуулсан.

Нөгөөтэйгүүр оргон зайлсан ялтныг эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах төсөв зардал, хүн хүчний талаар тодорхой зохицуулсан эрх зүйн

зохицуулалт холбогдох эрх зүйн актуудад тусгагдаагүй байгаа нь хүний нөөц болон санхүүгийн хувьд тулгамдаж буй асуудал болоод байна.

Зураг 39. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 34 шийдвэр гүйцэтгэгчээс "Үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал"-ын талаар авсан судалгааны дүн.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн албаны 2021 оны 10 дугаар сарын мэдээгээр Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн нийт 12209 ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласнаас 446 ялтан хасагдаж, нийт гүйцэтгэвэл зохих 11763 ялтнаас 8134 ялтны ялыг бүрэн биелүүлж, 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 3629 ялтны үлдэгдэлтэй байгаагаас зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн нийт 687272 хоногийн 1431 ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласнаас хасагдсан 78 ялтны 37474 хоног, нийт гүйцэтгэвэл зохих 1353 ялтны 649798 хоногийн ялыг эдлүүлэхээс 261 ялтны 66991 хоногийн ялыг бүрэн, 1092 ялтны 97386 хоногийн ялыг хэсэгчлэн эдлүүлж, 1092 ялтны 485421 хоногийн тус тус үлдэгдэлтэй байна.

Улсын хэмжээнд 42 эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нараас зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн этгээдэд хяналт тавихад учирч буй хүндрэлийг тодорхойдох зорилгоор судалгаа авахад 34 эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч оролсоноос 1-3 жил ажиллаж байгаа 23, 4-6 жил ажиллаж байгаа 2, 7-10 жил ажиллаж байгаа 4, 5-7 сар ажиллаж байгаа 2 тус тус хариулсан байна.

1. Зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт хэр оновчтой байна гэж үзэж байна вэ?

Сайжруулах шаардлагатай – 26	76,47%
Хангалтгүй- 7	20,5%
Сайн-1	2,9%

Зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх явцад ялтнаас ямар төрлийн зөрчлийг илүү гаргаж байна вэ

Цахим бугуйвч цэнэггүй болгох-15	44,1%
Чанарын шаардлага хангахгүй-1	2,9%
Үгүй-1	2,9%
Бүс зөрчих-7	20,5%
Оргон зайлах-6	17,6%
Оргон зайлж, дахин гэмт хэрэг үйлдэх-3	8,8%
Цахим гавыг унтраах-2	5,8 %
Төлбөр төлөх боломжгүй-1	2,9%

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх, хяналт тавихад учирч буй хүндрэл бэрхшээл?

Сүлжээ доголдох-4	11,7%
Системийн хурд муу, гацах-5	17,7%
Оргон зайлах-1	2,9%
Цахим бугуйвчны цэнэг муу байдаг-7	20,5%
Цахим бугуйвчны эвдрэл их -3	8,8%
ШГА-ны зардал байхгүй-1	2,9%
Газар дээр нь биечлэн хяналт тавихад хүндрэлтэй-2	5,8%
Биечлэн болон эрэн хайх ажиллагааны зардал, тэдгээрт холбогдох зардал асуудалтай-8	23,5%
Эрэн сурвалжлах багтай болох-2	5,8%
Ялтны хаяг тодорхойгүй-3	8,8%
Алба хаагчын аюулгүй байдал хангалтгүй-2	5,8%
ШГ нарын ажлын ачаалал их-1	2,9%

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн санал хүсэлт /шийдвэрлэх арга зам/

Хууль, журмыг нарийвчлалтай болгох-3	8,8%
Ялтны хувийн байдлыг харгалзах-2	5,8%
Сүлжээ сайжруулах-5	14,7%
ЦЕГ-тай нэгдсэн журмаар хамтарч ажиллах-1	2,9%
Цахим бугуйвчыг сайжруулах-10	29,41%
ШГА-ны зардлыг шийдвэрлэх-1	2,9%
Эрэн хайх багтай болох-3	8,8%

Хяналтын зардлыг өөрөөсөө гаргадаг /ШГ нарын гар утасны зардлыг шийдвэрлэх/-1	2,9%
Үүрэн холбооны сүлжээ ашиглахгүй хяналт тавьдаг болох-2	5,8%

Дүгнэлт

Шинэ ажил хэрэгжүүлэхэд алдаа оноо гарах, хэрэгжилтийг нэг мөр болгоход асуудал түгээмэл байдаг хэдий ч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийхгүй орхих, техникийн боломжид баригдах нь эрүүгийн хариуцлага, ялын зорилго, үр нөлөөг бууруулах, ялтанд завшуулах, ял гарцаагүй байх зарчим алдагдах нөхцөл байдлыг үүсгэхээр байна.

Өнөөдрийн тухайд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй хяналтын тоног төхөөрөмж шаардлага хангахгүй буюу үүрэн холбооны /2 G сүлжээ/-ний /GPS/ нь байршил буруу заадаг, ялтанд зүүлгэсэн цахим бугуйвч цэнэглэхэд хүдрэлтэй, цэнэг хангалтгүй барьдаг зэрэг нь ялтныг техникийн тасралтгүй хяналтаас алдах эрсдэлийг үүсгэж байна.

Түүнчлэн аймаг, нийслэл дэх хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны шийдвэр гүйцэтгэгч нараас авсан судалгаанаас дүгнэхэд ялтан оргон зайлсан тохиолдолд эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулах нэгж, санхүүгийн үүсвэр тодорхойгүй байгаа нь алба хаагчдад ажлын ачаалал, эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг бий болгож байна.

Шинэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд тулгарч буй "хүндрэл, бэрхшээл"-ийг шийдвэрлэхэд гадаадын улс орнуудын тусламж дэмжлэг авах, төсөл хөтөлбөрт хамтарч ажиллах нь одоогийн нөхцөлд оновчтой шийдвэр боловч цаашид өөрийн орны эрдэмтэн судлаач, зохион бүтээгчдийн "инновац"-ийн бүтээлийг ашиглаж ялын хэрэгжилтийг хангахад ашиглаж буй "тоног төхөөрөмж, техник хэрэгсэл"-ийг Монгол Улс өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан дотооддоо үйлдвэрлэж, эдийн засгийн бодит хэмнэлт гаргах боломжтой гэж дүгнэж байна.

Зөвлөмж

1. “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Зорчих эрхийг хязгаалах ял шийтгүүлсэн ялтан зардал, хохирол нөхөн төлөх шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн этгээд ялын хугацаа дуусахаас өмнө 30 хоногийн өмнө зардлыг бүрэн барагдуулсан байна” гэсэн хэсэгт - “Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан үүрэн холбооны операторын төлбөрийг хяналтын тоног төхөөрөмж зүүхээс өмнө нийт ял эдлэх хугацаагаар тооцоолж төлнө” гэсэн заалт шинээр нэмэх.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, газруудад оргон зайлсан ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий бүтцийг бий болгох. Энэ нь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачааллыг буруулах ач холбогдолтой.

3. Оргон зайлсан ялтныг эрэн сурвалжлах ажиллагааны гарсан зардлыг тухайн ялтан этгээдээр нөхөн төлүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр оруулах.

4. Тодорхой оршин суух хаяггүй этгээдэд зорчих эрхийг хязгаарлах ялыг ногдуулахгүй байх эрх зүйн зохицуулалтыг эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлтөөр оруулах зэрэг зөвлөмжийг хүргүүлж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2017.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Б.Алтангэрэл. "Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ" судалгааны ажлын тайлан. УБ., 2018 он
2. Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам /Харьцуулсан судалгаа/ судалгааны тайлан. 2016 он
3. Б.Баярсайхан, С.Жанцан. "Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он)". УБ., 2001 он
4. Б.Содовсүрэн. "БНМАУ-ын Эрүүгийн эрх". УБ., 1969 он
5. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1989 он
6. Т.Дэндэв. "БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн тухай асуудал". УБ., 1975 он
7. Б.Нямгомбо. "Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага". 2015 он

Гурав. Гадаад хэл дээрх материал:

1. Hans-Joerg Albrecht. Electronic Monitoring in Europe. A Summary and Assessment of Recent Developments in the Legal Framework and Implementation of Electronic Monitoring.
2. Mortimer, E., May, Ch.: Electronic monitoring in practice: the second year of the trials of curfew orders. London: Home Office 1997.
3. Bishop, N.: Le controle intensif par surveillance electronique: un substitut suedois a l' emprisonnement. Bulletin d' information penologique 19/20(1995),
4. Ministry of Justice: Electronic Monitoring. The Hague 1996.
5. Haferkamp, R.: Elektronisch überwachter Hausarrest - Europa und die Schweiz. Neue Kriminalpolitik 1999.
5. Mayer, M., Haverkamp, R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg 2003.
6. Ceron I Riera, M.: The Pilot Project on Electronic Monitoring in Catalonia, Spain. In: Mayer, M., Haverkamp, R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg 2003.
7. Schädler, W.: The Pilot Project on Electronic Monitoring in Frankfurt, Germany. In: Mayer, M., Haverkamp.
8. R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg 2003.
9. M.: Modellprojekt Elektronische Fußfessel. Wissenschaftliche Befunde zur Modellphase des hessischen Projekts. Freiburg 2004.
10. Nacro Youth Crime 2002, "Electronic monitoring of children remanded on bail or to local authority accommodation", Youth Crime Briefing, June.

11. Matt Black and Russell G. Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology. Canberra. 2003.
12. Section 44 (3) (b), Sentencing Act 1995 (NT).
13. Gable, Ralph K., and Robert S. Gable. 2005. "Electronic Monitoring: Positive Intervention Strategies." Federal Probation 69(1). Kansas Department of Corrections. 2014.
14. National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. Keeping Track of Electronic Monitoring. Washington D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.
15. William D., Karen Mann, Thomas G. Blomberg, Gerald G. Gaes, Kelle Barrick, Karla Dhungana, and Brian McManus. 2010. "A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring." Tallahassee, Fla.: Florida State University, College of Criminology and Criminal Justice, Center for Criminology and Public Policy Research.
16. Stephen V., Randy Gainey, Marcia I. Cohen, Eoin Healy, Martha Yeide, Alan Bekelman, Amanda Bobnis. 2013. Monitoring High-Risk Gang Offenders with GPS Technology: An Evaluation of the California Supervision Program Final Report. Bethesda, MD: Development Services Group.
17. Bonta, James, Suzanne Wallace-Capretta, and Jennifer Rooney. 2000. "Can Electronic Monitoring Make a Difference? An Evaluation of Three Canadian Programs."
18. Wiebush, Richard G. 1993. "Juvenile Intensive Supervision: The Impact on Felony Offenders Diverted from Institutional Placement."
19. Development Services Group, Inc. 2014. "Home Confinement and Electronic Monitoring." Literature Review. Washington, DC.: Office of Juvenile Justice and Delinquency Prevention.
20. Sklaver, Stacey L. 2010. "The Pros and Cons of Using Electronic Monitoring Programs in Juvenile Cases." Juvenile Justice Committee Newsletter, No.5. Washington, D.C.: American Bar Association.
21. Harvard Law Review 1966-67.
22. Gable (former Ralph Schwitzgebel), Journal of Criminal Justice 1986.
23. Schwitzgebel, Law and Computer Technology 1969.
24. Schwitzgebel, Lex et Scientia 1968.
25. Jolin/Rogers, Journal of Contemporary Criminal Justice 1989.
26. Schmidt, Journal of Contemporary Criminal Justice 1989.
27. RITA HAVERKAMP. Implementing Electronic Monitoring A comparative, empirical study on attitudes towards the measure in Lower Saxony/Germany and in Sweden.
28. G Mair; C Nee. Electronic Monitoring: The Trials and Their Results. 1990.
29. Compare the overview of the average prison population of Walmsley 1998.
30. Haverkamp, in: Neue Kriminalpolitik 1999/4.
31. James Kilgore. Electronic Monitoring Is Not the Answer Critical reflections on a flawed alternative. Urbana-Champaign Independent Media Center A part of the Media Action Grassroots Network (MAG-Net). 2015.
32. National Law Enforcement and Corrections Technology Center Bulletin, Keeping Track of Electronic Monitoring, Oct. 1999.

33. Jeff Abell, Juvenile Offenders Housing Costs Spike: Board Explores Pulling Juveniles from Lee County Center, THE HAWK EYE, Mar. 5, 2010 available at 2010 WLNR 4744738.

34. Rex Smith, A Useful, Imperfect Tool Despite the Tragic Shooting of a 5-Year-Old, GPS Monitoring has a Proven Track Record, BALTIMORE SUN, Oct. 23, 2009 at 21A, available at 2009 WLNR 21055672.

35. Adam Folk, Courts Official Reports Threats Incident Followed Hearing for Teens, AUGUSTA CHRONICLE, May 14, 2010 at B01, available at 2010 WLNR 10982345.

36. OJJDP Model Programs Guide, Home Confinement/Electronic Monitoring.

37. Tarrant County, Immediate Home Detention – Electronic Monitoring.

38. Tarrant County, Immediate Home Detention – Electronic Monitoring.

39. Rex Smith, A Useful, Imperfect Tool Despite the Tragic Shooting of a 5-Year-Old, GPS Monitoring has a Proven Track Record, BALTIMORE SUN, Oct. 23, 2009 at 21A, available at 2009 WLNR 21055672.

40. Laura Maggi, Arrests Show Limits of Ankle Bracelets, NEW ORLEANS TIMES PICAYUNE, Mar. 14, 2009 at 1, available at 2009 WLNR 4861958; Michelle Casady, Staying on top of truancy, THE EAGLE, Jan. 20, 2010, available at 2010 WLNR 1213591.

41. Newport News Department of Juvenile Services, Electronic Monitoring Program,

42. Michael T. Charles, Research Notes: Juveniles on Electronic Monitoring, 5 JOURNAL OF CONTEMPORARY CRIMINAL JUSTICE ONLINE 165, 167 (1989).

43. John F. Tewey, Maryland Task Force to Study Criminal Offender Monitoring by Global Positioning Systems, Final Report to the Governor and General Assembly (Dec. 31, 2005), available at.

44. Julie D. Bowden et al., Issues Pertaining to the Juvenile Defendant at Trial, MA-CLE § 11.2.1 (2009)

45. Joe Moszczyński, Sussex will Charge Parents a Fee for Youths' Home Confinement, THE STAR-LEDGER, Apr. 18, 2010 at 29, available at 2010 WLNR 8034412.

46. ФСИН России: Ведомственная целевая программа «Внедрение современных информационно-коммуникационных технологий в деятельность Федеральной службы исполнения наказаний на 2011–2013 годы». М., 2010. С. 66. (хандалт-10.01.2018 он)

47. Федеральное государственное унитарное предприятие "Центр информационно-технического обеспечения и связи Федеральной службы исполнения наказаний <http://www.citosfsin.ru/company/index.php> (хандалт-10.01.2018 он)

48. Ralph K., and Robert S. Gable. 2005. "Electronic Monitoring: Positive Intervention Strategies." Federal Probation 69(1). Kansas Department of Corrections. 2014. House Arrest—Juvenile Corrections. Olathe, Kan.: Johnson County Department of Corrections.

49. Darren. 2000. "Overview of the Federal Home Confinement Program 1988-1996." Federal Probation 64(2). 11-18.

50. Matt Black and Russell G. Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology. Canberra. 2003.

Дөрөв. Цахим хаяг:

1. www.ojjdp.gov
2. www.criminologycenter.fsu.edu
3. www.ncjrs.gov
4. www.npr.org
5. www.justnet.org
6. www.dsgonline.com
7. www.tarrantcounty.com
8. www.nngov.com
9. www.dpscs.state.md.us
10. www.fmc.uz
11. www.legislationline.org
12. www.competition.am
13. www.consultant.ru

ХАВСРАЛТ

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ЯЛТНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

2021 оны 9 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд нийт 1068 иргэн зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн байна.

НИЙСЛЭЛД 545, ОРОН НУТАГТ 523 ИРГЭН ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН .

Үүнээс нийслэлд ял шийтгэгдсэн эрэгтэй 525, эмэгтэй 20, орон нутагт эрэгтэй 502, эмэгтэй 21 ялтан тодорхой чиглэлээр зорчих эрхээ хасуулан ял эдэлж байна.

МУ-ын эрүүгийн хууль

Монгол Улсын эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5-д Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараа таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.



Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хүрээнд 2 хүүхдэд уг ялыг оногдуулсан байна.



Ял шийтгүүлсэн нийт ялтны 1066 насанд хүрсэн, өсвөр насны 2 иргэн тус тус ял эдэлж байна.



МУ-ын эрүүгийн хууль

Монгол Улсын эрүүгийн хуулийн 5.5.3-д Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.



Нийт системд бүртгэгдсэн ялтны тоо 1265 байгаагаас ялын хугацаа дуусч-104, ял сольсон-91, түтгэлзүүлсэн-2. Өмнө нь ял шийтгүүлж байсан 497 буюу 39,3%, анх удаа гэмт хэрэг үйлдсэн 768 буюу 60,7% байна.



Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт

ШИНЭЧЛЭН БАТАЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ 2017 ОНД ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭНТЭЙ ЖОЛБОГДУУЛАН ЭРҮҮГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙГ БИЕ ДААСАН ХЭЛБЭРЭЭР АЖИЛЛУУЛЖ, АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАН, ШИНЭ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР АЖИЛЛАЖ ЭХЭЛСЭН.


34 Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нараас авсан асуулгын дүн

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫГ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХЭР ОНОВЧТОЙ БАЙНА ВЭ? ГЭСЭН АСУУЛТАНД


Сайжруулах шаардлагатай – 26 76,47%
Хангалтгүй – 7 20,5%
Сайн – 1 2,9%



Зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх явцад ялтнаас ямар төрлийн зөрчлийг илүү гаргаж байна вэ?



Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх, хяналт тавихад учирч буй хүндрэл бэрхшээл?



ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн санал хүсэлт /шийдвэрлэх арга зам/

**ХУУЛЬ, ЖУРМЫГ
НАРИЙВЧЛАЛТАЙ
БОЛГОХ-3 БУЮУ 8,8 %**



**СҮЛЖЭЭ
САЙЖРУУЛАХ-5 БУЮУ
14.7 %**



**ЦАХИМ БУГУЙВЧЫГ
САЙЖРУУЛАХ-10 БУЮУ
29,41 %**



**ХУУЛЬ, ЖУРМЫГ
НАРИЙВЧЛАЛТАЙ
БОЛГОХ-3 БУЮУ 8,8%**



**ҮҮРЭН ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
АШИГЛАХГҮЙ ХЯНАЛТ ТАВЬДАГ
БОЛОХ-2 БУЮУ 5,8 % ТУС ТУС
ХАРИУЛСАН БАЙНА.**